

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО,
ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ”-д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БНА-2024/19-3-ШТА-ГА

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮНИЙ
НӨӨЦИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ БАТЛААГҮЙ БАЙНА.

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу
Цахим хуудас: www.tailan.audit.mn

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга,**
тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 цахим хуудас: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: : 70442424 цахим хуудас: doljmaab@audit.gov.mn

Аудитор Н.Бүнчинсүрэн

Утас: : 70442424 цахим хуудас: bunchinsurenn@audit.gov.mn

Аудитор Д.Цэдэвцэвээн

Утас: : 70442424 цахим хуудас: tsedevtseveend@audit.gov.mn

Баянхонгор хот 2024 оны 11 дүгээр
сарын 20-ны өдөр

Тайланг хянасан:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Тайланг бэлтгэсэн:

Аудитын менежер М.Алтантуяа

Ахлах аудитор Б.Должмаа

Аудитор Н.Бүнчинсүрэн

Аудитын судалгааг нэгтгэсэн:

Аудитор Д.Цэдэвцэвээн

Аудитор Г.Энхзул

Аудитор А.Адилзаяа

2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

Тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:
Үндэсний аудитын газар
Засгийн газрын IY байр
Бага тойруу-3, Чингэлтэй
дүүрэг, Улаанбаатар хот
15160
Монгол Улс

АГУУЛГА

БҮЛЭГ 1. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ БАТЛААГҮЙ БАЙНА. 6

1.1.Төрийн байгууллагуудын хүний нөөцийн асуудлыг зохицуулж байгаа хууль тогтоомжийг албан хаагчдад ээлтэй, эрх ашгийг хамгаалахаар баталж мөрдсөн байгаа ч хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллаж чадахгүй байна.6

1.2. Хөдөө орон нутагт ажиллах боловсон хүчин дутагдалтай байна. ... 11

1.3. Төрийн албаны зөвлөлийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчилтэй томилгоо жил бүр давтагдан гарсан, өмнөх жилийн зөрчлийг бүрэн арилгаагүй байна. 13

БҮЛЭГ 2. ИРГЭД, ОЛОН НИЙТЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛД ҮНДЭСЛЭН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ, ЦАХИМ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ НЭВТРҮҮЛЭХЭД ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫГ СУРГАЖ, ЧАДВАРЖУУЛАХ БАЙДАЛ ДУТМАГ БАЙНА.....26

2.1. Цахимжсан, түргэн шуурхай, хүртээмжтэй төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд төрийн албан хаагчдыг цахим хэрэглээний мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд хүргэж байна..... 26

2.2. И-Монголиа ашиглан систем хооронд өгөгдөл солилцох үйл ажиллагааг хөгжүүлснээр иргэд шаардлагатай мэдээллийг цахимаар хүлээн авч байгаа нь цаг хугацаа, эдийн засгийн хэмнэлтийг бий болгосон байна. 31

2.3 Төрийн үйлчилгээний ил тод, нээлтэй байдлыг 16 салбараар үнэлсэн иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа “Дунд” үнэлгээтэй байна. 32

ДҮГНЭЛТ.....35

ЗӨВЛӨМЖ.....36

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААР ДАМЖУУЛАН ХОЛБОГДОХ ГАЗРУУДАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ.....37

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ТАГ	Төрийн аудитын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
МУИХ	Монгол улсын их хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт дотоод аудитын алба
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТАСЗ	Төрийн албаны салбар зөвлөл
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ХШҮДАХ	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ТЗУХ	Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс
АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт дотоод аудитын алба
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТАСЗ	Төрийн албаны салбар зөвлөл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны А/162 дугаар тушаал, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах” тухай 2024 оны А/1 дүгээр тушаалын дагуу аудитыг гүйцэтгэв.
Аудитын зорилт	Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг ҮАГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэв. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ✓ Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн эсэх; ✓ Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байгаа эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитаар төрийн зорилт, чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлдэг төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа явуулдаг бүтэц, зохион байгуулалттай төрийн захиргааны, тусгай, үйлчилгээний байгууллагуудын хүний нөөцийн, бодлогын, хяналт шинжилгээ дотоод аудитын албад нь өөрийн болон өөрт хамаарах байгууллагуудын хүний нөөцийн бодлогыг оновчтой тодорхойлсон, боловсруулсан, баталгаажуулсан байдлыг үзсэн. Аудитад Баянхонгор аймгийн ЗДТГ, ТАСЗ, Баянхонгор аймгийн Засаг даргын харьяа байгууллагууд, харьяа 22 агентлагуудыг хамруулсан. ҮАГ-ын нэгтгэсэн судалгаанд Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас албан бичгээр судалгааг гаргаж өгөх боломжгүй гэсэн тайлбарыг өгсөн тул нэгтгэгдээгүй болно.
Аудитын арга зүй	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажилласан.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: – Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль; – Төрийн албаны тухай хууль; – Авлигын эсрэг хууль; – Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль; – Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; – Байгууллагын нууцын тухай хууль; – Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль; – Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль; – Захиргааны ерөнхий хууль; – Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль; – Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль; – Монгол Улсын Засгийн газрын тухай хууль; – Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль; – Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль; – Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль; – Нийгмийн даатгалын ерөнхий хууль; – Төрийн болон албаны нууцын тухай хууль; – Төрийн хэмнэлтийн тухай хууль; – Төсвийн тухай хууль; – Хөдөлмөрийн тухай хууль; – Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль; – Хууль тогтоомжийн тухай хууль; – Шилэн дансны тухай хууль; – Төрийн байгууллагын хүний нөөцийн бусад холбогдох эрх зүйн актууд.
Хүндрэл бэрхшээл	• ҮАГ-ын ГНАГ-аас бэлтгэн ирүүлсэн нэгдсэн судалгаа 2 ба 3 нь 2012 оноос 2023 он хүртэл хугацаагаар авахад байгууллагуудын төсвийн захирагч, нягтлан бодогч нар солигдсон, архивын баримт олдохгүй шалтгаанаар судалгааг бүрэн ирүүлэхгүй байх, тоон мэдээллийг буруу, зөрүүтэй гаргаж ирүүлснээс дахин давтан тодруулж шалгасан нь цаг хугацаа их шаардсан; • Баянхонгор аймгийн ЗДТГ-ын хүний нөөцийн мэргэжилтэн нь зөвхөн аймгийн ЗДТГ-ын судалгааг гаргаж, аймгийн хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг нэгтгэж тайлагнахгүй байгаагаас аудитад шаардлагатай зарим мэдээллийг нэгтгэн гаргуулахад хүндрэлтэй байсан; • Баянхонгор аймгийн ТАСЗ-ийн өмнөх жилүүдийн ТАЗ-д хүргүүлсэн тайлангийн хавсралт мэдээллүүдийг ТАГ-т ирүүлээгүйгээс тайланд дурдсан тоон мэдээллийг нэгтгэх, нягтлах боломжгүй байсан;

АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ БАТЛААГҮЙ БАЙНА.

1.1. Төрийн байгууллагуудын хүний нөөцийн асуудлыг зохицуулж байгаа хууль тогтоомжийг албан хаагчдад ээлтэй, эрх ашгийг хамгаалахаар баталж мөрдсөн байгаа ч хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллаж чадахгүй байна.

1.1.1. Төрийн байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц нь Монгол Улсын дунд, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцэж байна уу? гэсэн асуудал АНТАГ-ын түвшинд бичигдээгүй, ҮАГ-т хамааралтай болно.

1.1.2. МУИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Тав.Засаглалын Ухаалаг бүтэц Зорилт 5.2¹-т заасны дагуу төрийн байгууллагууд эрх бүхий байгууллагаас баталсан бүтцийн хүрээнд ажилласан байна.

Аймгийн нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, аймгийн хэмжээний хүний нөөцийн нэгдсэн бодлого, төлөвлөлт хийх суурь судалгааг боловсруулах чиглэлээр 2 арга хэмжээг төлөвлөсөн ч хэрэгжээгүйгээс Баянхонгор аймгийн хэмжээнд хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлт, нийгмийн баталгааг хангах, боловсон хүчнийг хөгжүүлэх, сургах, урамшуулах зэргийг тусгасан хүний нөөцийн бодлогын баримт бичгийг батлаагүй байна.

Төрийн албаны хүний нөөцийг чадварлаг боловсон хүчнээр хангах, төрийн албаны чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг иргэдэд нээлттэй, ил тод, шуурхай хүргэхэд чиглүүлэн ажиллуулахыг аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг богино хугацааны бодлогын баримт бичигт тусган, хэрэгжилтийг тооцож иржээ.

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 2/7 дугаар тогтоолоор “Баянхонгор аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дөрөв. Засаглалын бодлогод төрийн албыг түргэн шуурхай болгож, иргэдийг төрийн нэгдсэн бодлого, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэх зорилгын дор 3 зорилтын хүрээнд 5 арга хэмжээг төлөвлөсөн байна. Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ээс тус 5 арга хэмжээний хэрэгжилтийг 2021 оны эцэст үнэлж, 3 арга хэмжээг 100 хувиар, 1 арга хэмжээг 50 хувиар, 1 арга хэмжээг 10 хувиар, дунджаар 72 хувиар үнэлсэн байна.

ЗГХЭГ-ын ХШҮГ-ын ажлын хэсэг 2021 онд Баянхонгор аймагт ажиллан, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт зөвлөн тусалж, үүний дагуу аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 08-ны А/57 дугаар захирамжаар “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний төлөвлөгөөг баталж, өмнөх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн Засаглалын бодлогод тусгасан 5 арга хэмжээг нэгтгэн 2 арга хэмжээ болгож баталжээ.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс дээрх хөтөлбөрийн 4.1.1-т “Төрийн мэргэшсэн албан хаагч 2022-2026 онд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ” арга хэмжээний хэрэгжилтийг 2022 онд 70 хувь, 2023 онд 100 хувь, 2024 оны эхний хагас жилд 90 хувьтай үнэлсэн байна.

¹ Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна.

Баянхонгор аймгийн хэмжээний хүний нөөцийн стратеги төлөвлөгөөг боловсруулж төсөв санхүүжилт, нөөцийг тодорхойлж, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж ажиллахаар аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө болон аймаг Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах саналыг тус тус хүргүүлсэн байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-аас ТАГ-т ирүүлсэн “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” 2023-2026 он” баримт бичигтэй танилцахад тус хөтөлбөрийг ямар ажлын хэсэг боловсруулсан нь тодорхой бус, тоон мэдээлэл зөрүүтэй, дутмаг, шийдвэр гаргахад мэдээлэл хангалттай бус, аймгийн ЗДТГ-ын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн гэх боловч хурлын тэмдэглэлийг ТАГ-т ирүүлээгүй болно.

Монгол Улсын алсын хараа 2050 дахь Зорилт 5 Засаглал, Шинэ сэргэлтийн бодлого Зорилт 6 “Төрийн бүтээмжийн сэргэлт”, Засгийн газрын хөтөлбөр, Баянхонгор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд заасан зорилтын хүрээнд Баянхонгор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь байгууллагын жилийн төлөвлөгөөг төлөвлөсөн байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 12.1-т “Аймгийн хэмжээний “Хүний нөөц” хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх” арга хэмжээг тусгасан боловч хэрэгжүүлж ажиллаагүй байхад биелэлтийг 100 хувиар тайлагнасан байгаа тул бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нийт албан байгууллагуудад хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ бүрээр нэгтгэж, тайлагнахыг аймгийн ТАСЗ-д зөвлөв.

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.2², 2.3³, ЗГХЭГ-ын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг мөрдөөгүйгээс Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн хүрээнд мөрдөх стратеги төлөвлөгөөг боловсруулж батлаагүй байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 02 тоот албан даалгавраар аймгийн ЗДТГ-ын дарга, холбогдох хэлтсийн дарга нарт “Аймгийн стратеги төлөвлөгөөг боловсруулж батлах”-ыг даалгасан боловч хэрэгжүүлээгүй байна.

Иймд Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн хүрээнд мөрдөх стратеги төлөвлөгөө болон аймгийн хэмжээнд мөрдөх хүний нөөцийн бодлогыг тодорхойлсон стратегийг боловсруулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

1.1.3. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Тав. Засаглалын 5.2.13 -т заасныг хэрэгжүүлж, Баянхонгор аймгийн хэмжээнд төрийн албан хаагчдыг чадавхжуулах, ёс зүйтэй төрийн албыг бий болгох асуудалд төрийн бүх байгууллагууд хамтран ажилласан боловч иргэний нийгэм, хувийн хэвшилтэй хамтран ажилласан байдал хангалтгүй байна.

² Төрийн албаны тухай хуулийн 53.1-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам нь тухайн сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулан төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

³ Яамны харьяа агентлаг нь байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулан салбарын сайдаар, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг аймаг, нийслэлийн Засаг даргаар тус тус батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулна.

Канад Улсын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийг ТАС-аас НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлсэн ба 2016 онд албан тушаалаас халагдсан, чөлөөлөгдсөн, түр чөлөөлөгдсөн зэргээр төрийн албанаас гарсан шилжилт хөдөлгөөн 14.23 хувь байсан бол 2022 оны байдлаар 6.59 хувь болж буурсан эерэг үзүүлэлттэй гарсан талаар ТАС-ын 2022 оны тайланд бичигдсэнээс үзэхэд төрийн албаны шинэтгэлийн эрх зүй, бодлогын баримт бичиг, аргачлалыг боловсронгуй болгосон, сургалт хөгжлийн бодлогод олон улсын шилдэг арга туршлагыг нэвтрүүлсэн нь үр дүн авчирчээ.

Тус хөтөлбөрийн хүрээнд Хүний нөөцийн аудитын суурь үзэл баримтлалыг боловсруулан Хүний нөөцийн аудитын гарын авлагыг боловсруулан, Хүний нөөцийн аудит хийх журмыг батлуулж, мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо нь Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлэн хөдөлмөрийн эрхийн маргааныг аль болох анхан шатанд харилцан тохиролцож эвлэрэх байдлаар зардал багатайгаар ажиллан 2013-2024 онд 441 хүний өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 322 зөвлөмж гаргасан байна. Ирсэн өргөдлийн 101 нь ажлаас халагдсан гомдол, 19 нь өөр ажилд хууль бусаар шилжүүлсэн, 285 нь цалин хөлсний маргаан байсан, хэлэлцсэн өргөдлийн 94.1 хувь нь өргөдөл гаргасан ажилтны талд шийдвэрлэсэн байна.

Иймд цаашид Хүний нөөцийн аудит хийх боловсон хүчнийг нэмэгдүүлэн, хөдөлмөрлөх эрхийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, сургалт явуулах зэрэг хүний нөөцийн бодлогын зорилтыг хэрэгжүүлэхдээ хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулж, хамтран ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

1.1.4. Жил бүр аймгийн ЗДТГ-аас төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхдээ хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг тусад нь үзүүлэлт болгон хэрэгжилтийг шалгаж иржээ.

ТАС3-ийн үйл ажиллагааны 2015 оны тайланд “2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 үндсэн зорилт дэвшүүлснээс 2-т Төрийн албаны хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилт зорилтыг дэвшүүлсэн ба “Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын удирдамж”-ийн дагуу ажилласан байна.

Баянхонгор аймаг дахь ТАС3-өөс 2016 оны эхний хагас жилийн байдлаар төрийн албан хаагчдын тоо бүртгэлийг нарийвчлан гаргах судалгааг аймгийн төрийн 172 байгууллагыг хамруулан Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар, “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоол, ЗГХЭГ-ын 2018 оны 255 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор Баянхонгор аймгийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/622 дугаар захирамжийн дагуу 2018 оны 09 дүгээр сард аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумдын ЗДТГ зэрэг 170 гаруй төрийн байгууллагын үйл ажиллагаанд 6 ажлын хэсэг 21 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллан, нийт 12 шалгуур үзүүлэлтээр хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг байгуулага бүрээр бэлтгэн хүргүүлсэн гэх боловч зөрчилд өгсөн чиглэл, зөвлөмж, тайланг олдоогүй гэх шалтгаанаар ТАГ-д ирүүлээгүй болно.

Баянхонгор аймгийн ТАСЗ, аймгийн Төрийн архивын тасаг, аймгийн ЗДТГ-ын дэргэдэх ХШҮДАХ хамтран 2019 оны 6 дугаар сард төрийн байгууллагын стандартыг хангуулах, хүний нөөцийн бодлого, төсвийн төлөвлөлтийг оновчтой хийх, төрийн байгууллагын хүний нөөцийн залгамж чанарыг бий болгох зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилон бүх төрийн байгууллагуудын бүтэц, орон тоо, цалин тогтоолт, ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээ, түүний биелэлтэд хяналт шалгалтыг анх удаа хийж, 4 ажлын хэсэг 20 сум, 22 агентлагуудад ажилласан байна. Тус хяналтад хамрагдсан 202 төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагын 152 нь албан хаагчийн хувийн хэргийг журмын дагуу шинэчилсэн, 179 байгууллага нь албан хаагчдыг чадавхжуулах сургалт, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөр боловсруулсан баталсан байна.

Баянхонгор аймгийн ТАСЗ-ийн 2019 оны 35 дугаар албан бичгээр аймгийн төвийн 184 төрийн байгууллагын төрийн албан хаагчийн хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлж, баяжилт хийж ажилласан байна.

Мөн 2019 оны 11-12 дугаар сард ТАСЗ, аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэстэй хамтран аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 22 агентлаг, 20 сумын 120 байгууллагын 2019 оны үйл ажиллагаа, төрийн албан хаагчдын хувийн хэрэг бүрдүүлэлт, төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах ажлыг хийсэн боловч 2019 онд хийсэн хяналт шалгалтын 2 ажлын хүрээнд цаашид анхаарах асуудлыг тусгасан тайланг ТАГ-т ирүүлээгүй болно.

Баянхонгор аймаг дахь ТАСЗ-ийн 2021 оны 08 дугаар тогтоолын дагуу төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийн хүрээнд сумдын төсөвт байгууллагууд болон аймгийн төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, 8 чиглэлийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтээр шалгахад удирдамж боловсруулан, 2 ажлын хэсэг байгуулсан байна. Тус шалгалтын удирдамжаар 169 байгууллагыг шалгахад 142 төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.

Тус шалгалтын дүнд үндэслэн ТАСЗ-ийн 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Ажил эрчимжүүлэх тухай” 10 дугаар тогтоолоор төсвийн захирагч нарт 12 зөвлөмжийг өгч, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлт үр дүнг тооцож ажиллахыг ТАСЗ-ийн дарга, гишүүдэд үүрэг болгосон боловч тус тогтоолын хэрэгжилтийг тооцож ажиллаагүй байна.

Баянхонгор аймаг дахь ТАСЗ-өөс “төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” ажлыг тусгаж хэрэгжүүлж байгаа ч нэгдсэн арга зүйгээр хангах зөвлөмж, чиглэл байгууллагуудад хүргүүлж, түүний мөрөөр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг авч нэгтгэн дүгнэх ажлыг хийгээгүй орхигдуулсан байна.

Иймд цаашид төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, бусад асуудалд тухай бүр томилогдсон ажлын хэсэг хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, илэрч буй алдаа, зөрчилд үндэслэн нэгдсэн арга зүй, зөвлөмжийг хугацаатай өгч, хэрэгжилтийг тооцож, үр дүнг нэгтгэн, аймгийн ИТХ болон олон нийтэд ил тод, нээлттэй тайлагнаж ажиллах зөвлөмжийг Баянхонгор аймаг дахь ТАСЗ-д хүргүүлэв.

Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах, ёс зүйн хэм хэмжээг сахиулах заалтыг байгууллагын дотоод журам, хамтын гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллаж иржээ.

Төрийн албан хаагчдын аймгийн “Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг 2009 оноос хойш жил бүр оны эхэнд хийж хэвшсэн ба төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, бүтээлч санал, санаачилгыг дэмжих, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, хариуцлагатай, хүртээмжтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор Баянхонгор аймаг дахь ТАСЗ-өөс сүүлийн 3 жил дараалан “Ёс зүй, хандлага зөвтэй төрийн албан хаагч” аяныг зарлаж, оны эцэст дүгнэн ажилласан нь төрийн албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх, хариуцлагыг нэмэгдүүлсэн сайн талтай байна.

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын хэрэгжилтийг аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудад шалгахад дараах зөрчил аудитаар илэрсэн.

Аудитын илрүүлэлт

- Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын ЗДТГ-ын дотоод ажил хариуцсан мэргэжилтний хувийн хэргийг аудитын багт ирүүлээгүй;
- Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчдын хувийн хэргийн бүрдэл хангалтгүй;
- Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчдын хувийн хэргийн бүрдэл хангалтгүй байна.

Иймд Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу 2025 онд ТЕЗ-ын харьяа бүх байгууллагын албан хаагчдын хувийн хэргийг шалгах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх зөвлөмжийг Баянхонгор аймаг дахь ТАСЗ-д хүргүүлэв.

Баянхонгор аймгийн ТАСЗ-ийн 2012-2014 оны архивын баримтад тус онуудад дарга, гишүүдээр ажиллаж байсан албан хаагчдын мэдээлэл байхгүй, ТАСЗ-ийн тайлангийн хавсралт файлуудыг ирүүлээгүйгээс 2012-2024 онуудын тоон мэдээллийг нэгтгэн дүгнэн дүн шинжилгээ хийх боломжгүй байдал үүссэн, баримт материалыг удаа дараа шаардуулсан нь аудит хийхэд хүндрэлтэй байсан тул цаашид мэдээ тайлангийн тоон мэдээллийг нотлох баримтаар бэлтгэж, цахим мэдээллийн санг нөхөн бүрдүүлэх, сангийн мэдээллийг жил бүр баяжуулж байх зөвлөмжийг Баянхонгор аймаг дахь ТАСЗ-д хүргүүлэв.

Мөн ТАЗ-ийн цахим хуудаст 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдөр оруулсан ТАСЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнийг шинэчлээгүй тул холбогдох арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна.

Баянхонгор аймаг дахь ТАСЗ-өөс аудитаар шаардсан ТАСЗ-ийн тайлангийн хавсралт файлуудыг ирүүлээгүйгээс 2012-2024 онуудын тоон мэдээллийг нэгтгэн дүгнэн дүн шинжилгээ хийх боломжгүй байдал үүссэн, баримт материалыг удаа дараа шаардуулсан нь аудит хийхэд хүндрэлтэй байсан тул цаашид мэдээ тайлангийн тоон мэдээллийг нотлох баримтаар бэлтгэж, цахим мэдээллийн санг нөхөн бүрдүүлэх, сангийн мэдээллийг жил бүр баяжуулж байх зөвлөмжийг Баянхонгор аймаг дахь ТАСЗ-д хүргүүлэв.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ыг Баянхонгор аймаг дахь ТАСЗ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Аудитын илрүүлэлт

- Журмын 5.1⁴-ийн 2 жил тутамд гаргах ахиц дэвшлийн тайланг ТАЗ-д хүргүүлээгүй;

⁴ Салбар зөвлөл нь тухайн жилийн үйл ажиллагааны хагас жилийн явцын тайланг 7 дугаар сарын 01-ний дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор, ахиц дэвшлийн тайланг 2 жил тутам тус тус гаргаж Төрийн албаны зөвлөлд хүргүүлж байна.

- Журмын 5.2⁵-т заасныг мөрдөөгүйгээс иргэд, албан хаагчдаар үнэлгээ хийлгэх, санал авч, түүний мөрөөр арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Иймд Баянхонгор аймгийн ТАСЗ-д салбар зөвлөлийн үйл ажиллагааг журмын дагуу тайлагнаж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Баянхонгор аймаг дахь ТАСЗ-ийн 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 138 дугаар тогтоолоор томилогдсон зөвлөлийн нарийн бичгийн даргаас бусад гишүүд давхар гүйцэтгэдэг, ТАСЗ-ийн даргаар аймгийн Засаг даргын захирамжаар томилогддог аймгийн ЗДТГ-ын дарга ажиллаж байгаа нь ТАЗ-ийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6⁶ дахь заалт хэрэгжих боломжгүй байдалд хүргэх эрсдэлтэй байна.

ТАСЗ-ийн ажлыг дарга, гишүүд хавсран гүйцэтгэж байгаа нь Төрийн албаны тухай хуулийг анхан шатанд хэрэгжүүлэхэд хүчгүйдэх, ажил хариуцсан албан хаагч ойр ойрхон солигдож байгаа зэргээс шалтгаалан тус зөвлөлийг орон тооны болгох саналыг Үндэсний аудитын газарт уламжлав.

ТАСЗ-өөс ТАГ-т 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 141 дүгээр албан бичгээр “Төрийн албаны зөвлөлийг орон нутагт бие даасан хараат бус байдлыг хангах зорилгоор байгуулж, бүтэц орон тоог нэмэгдүүлэх” санал ирүүлснийг ҮАГ-аар дамжуулан ТАЗ-д уламжлуулахаар хүргүүлэв. /Хавсралт 1/ Үүнд:

- ✓ Төрийн албаны зөвлөлийг орон нутагт бие даасан хараат бус байдлыг хангах зорилгоор байгуулж, бүтэц орон тоог нэмэгдүүлэх”
- ✓ Төрийн албаны тухай хууль бусад хуультай зөрчилдөх асуудалд хяналт шинжилгээ хийж зөрчлийг арилгах
- ✓ Төрийн үйлчилгээний статуст ажиллах боломжтой албан тушаалыг ангилан төрийн үйлчилгээний ангилалд оруулах, тус албан тушаалуудад заавал ерөнхий шалгалт өгсөн байх иргэдийг шаарддаг тул энэ нь сул орон тоо гарах нөхцөлийг бүрдүүлж байна /сумдын байгаль хамгаалагч, багийн зохион байгуулагч, багийн нийгмийн ажилтан, тархвар зүйч гэх мэт/
- ✓ Төрийн албаны салбар зөвлөлд томилгооны зөрчлийн асуудлыг бие даан шийдвэрлэх эрхийг олгох. Тухайлбал зөрчилтэй томилгоог хүчингүй болгох, өргөдөл гомдлыг шийдвэрлэх
- ✓ Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлах, нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг яаралтай шийдвэрлэх зэрэг асуудлыг тусгажээ.

1.2. Хөдөө орон нутагт ажиллах боловсон хүчин дутагдалтай байна.

1.2.1. Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 08 дугаар тогтоолын дагуу төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийн хүрээнд сумдын төсөвт байгууллагууд болон аймгийн төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөн туслах ажлыг зохион байгуулахдаа төрийн байгууллагуудын сул орон тооны мэдээллийг авч дүн шинжилгээ хийгээгүй, өөрөөр хэлбэл аймгийн хэмжээнд дутагдалтай орон тооны судалгааг гаргаагүй байгааг аудитын явцад Баянхонгор аймгийн ЗДТГ-ын дарга,

⁵ Салбар зөвлөл нь үйл ажиллагаагаа олон нийтэд (цахим хуудсанд) жилд 2-оос доошгүй удаа тайлагнаж, иргэд, төрийн албан хаагчдаас өгсөн үнэлгээ, санал, шүүмжлэлийн мөрөөр тодорхой арга хэмжээ авч, үр дүнг хариу мэдээлнэ. Энэхүү үнэлгээг Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хагас, бүтэн жилийн тайлантай хамт Төрийн албаны зөвлөлд ирүүлж байна.

⁶ Салбар зөвлөл нь орон тооны, орон тооны бус эсэхээс үл хамааран өөрийн үйл ажиллагааг аливаа байгууллага, албан тушаалтнаас хараат бус, бие даасан байдлаар явуулна.

хүний нөөцийн мэргэжилтнээс орон нутгийн хэмжээнд дутагдалтай байгаа хүний нөөцийн судалгааг нэгтгэж гаргаж ирүүлээгүй.

Иймд орон нутгийн хэмжээнд хүний нөөцийн судалгааг гаргаж, дүн шинжилгээ хийж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1-т “Аймгийн хэмжээнд шаардлагатай байгаа мэргэжилтэй боловсон хүчний нөөцийн судалгааг хийх” ажлыг баталсан байна. Тус арга хэмжээний хүрээд салбар зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 05 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд хэрэгцээтэй байгаа мэргэжилтэй боловсон хүчний судалгааг гаргах ажлын хэсгийг томилж, судалгааг хийсэн гэх боловч судалгаа хийсэн болон шийдвэрлэсэн талаарх баримт материалыг ТАСЗ-өөс ТАГ-т ирүүлээгүй болно.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын захиалгаар Худалдаа аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбар 2022 онд “Баянхонгор аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа”-г, 2023 онд “Баянхонгор аймгийн хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн судалгаа”-г орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэжээ.

Судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийгээгээс бодлогын баримт бичиг байхгүй байгаа тул цаашид төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх үүднээс хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа, өнөөгийн чиг хандлагыг тодорхойлох судалгааны ажилд мэргэжлийн байгууллагууд, бодлого тодорхойлох чиг үүрэг бүхий алба, хэлтсийн албан хаагчдыг оролцуулах, судалгааны үр дүнг холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлж, аймгийн бодлого, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангаж ажиллах нь зүйтэй байна.

Орон нутагт ажиллах боловсон хүчний нөөц байнга дутагдалтайгаас албан хаагчид давхар ажлыг гүйцэтгэх, удаан хугацаагаар сул орон тоо нөхөгдөхгүйгээс ажлын ачаалал нэмэгдэх, хөдөө сумдад тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл байдал алдагдаж байна.

Аудитын явцад дутагдалтай орон тооны судалгааг хийхэд дараах байдалтай байна.
Үүнд:

- ✓ Баянхонгор аймгийн БСУГ-аас 38 багшийн орон тоо дутагдалтай, үүнийг тэтгэвэрт гарсан багш нараас нөхсөн;
- ✓ Баянхонгор аймгийн ЭМГ-аас сумдын эрүүл мэндийн төвүүдэд 58, аймгийн Нэгдсэн эмнэлэгт 49, ЭМГ-т 6, нийт 114 орон тоо дутагдалтай байна. Ирүүлсэн судалгаанаас үзэхэд сумдын нийт дутагдал орон тооноос их эмч 15, бага эмч 14 байгаа бөгөөд сумдын ЭМТ-д ажиллаж байгаа албан хаагчид хавсран гүйцэтгэж байгаа бөгөөд улсын хэмжээнд бага эмчийг бодлогын түвшинд сургахгүй байгаагаас бага эмчийн орон тооны дутагдал үүссэн байна. Баянхонгор аймгийн ЭМГ-ын дутагдалтай орон тоог ТАСЗ-д хүргүүлж, ажлын байрыг нийтэд зарласан байна.
- ✓ Баянхонгор аймгийн СТСХ-ээс ирүүлсэн мэдээллээр сумдад нягтлан бодогчийн 5, санхүүгийн албаны даргын 3, төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний орон тоо 3 дутуу байна. Баацагаан, Галуут сумд санхүүгийн ажилтны дутагдалтайгаас санхүүгийн албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтнийг 2019 оны 6 сараас хойш хавсран гүйцэтгэж байгаа ба сул орон тоог нөхөх шалгалтад орох хүн байхгүй гэх шалтгаанаар өнөөг хүртэл хавсран гүйцэтгэж байна. Галуут, Богд, Гурванбулаг сумдад нягтлан бодогчийн орон тоо дутагдалтайгаас 1 нягтлан бодогч 3-4 байгууллагын нягтлан бодогчийн ажлыг давхар хийж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлж байна.

- ✓ Баянхонгор аймгийн төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх төрийн захиргааны 95 ажлын байрны сонгон шалгаруулалтыг зарласнаас сумдад 61, аймгийн төвд 34 ажлын байр сул байна.

1.2.2. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд Шил ажиллагааны хүрээнд Shilen.gov.mn, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу мэдээллийг ил тод мэдээлж, мэдээлсэн байдалд аймгийн ЗДТГ-ын ХШҮХ хяналт хэрэгжүүлэн ажилласан байна.

1.2.3 ТАСЗ-д ирүүлсэн сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу ажиллажээ.

1.3. Төрийн албаны зөвлөлийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчилтэй томилгоо жил бүр давтагдан гарсан, өмнөх жилийн зөрчлийг бүрэн арилгаагүй байна.

1.3.1. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Тав.Засаглалын Ухаалаг бүтэц Зорилт 5.2-ын “Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна” зорилтын хүрээнд 5.2.2⁷-т заасны дагуу Баянхонгор аймгийн төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, албан тушаалын болон чиг үүргийн давхардлыг тодорхойлсон баримт материал олдоогүй болно.

Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд 13 бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг Баянхонгор аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан igovernment цахим хуудсаар мэдээлж, орон нутгийн хэмжээнд хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ гүйцэтгэж, цахим хуудаст мэдээлснийг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ үнэлж дүгнэн Засгийн газарт хүргүүлж байна.

ТАЗ-ийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын албан тушаалын зорилго, зорилт, чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх төрийн албан хаагчид тавигдах шаардлагыг чадахуйн зарчимд нийцүүлэх зорилгоор “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ийг баталсан байна.

Баянхонгор аймаг дахь ТАСЗ нь дээрх журмын 2.4-т заасан аргачлал, Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын дагуу аймгийн төрийн захиргааны 35 байгууллагад ажлын байрны шинжилгээ хийж, шалгалтын үр дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилган, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдааг сайжруулах зорилгоор 487/+361+126/ албан тушаалын тодорхойлолтыг шинээр боловсруулан ТАЗ-д батлах зөвшөөрөл авахаар хүргүүлж, батлах зөвшөөрлийг авч, төсвийн шууд захирагчаар батлуулжээ.

Аймгийн хэмжээний төрийн үйлчилгээний албан тушаалын тодорхойлолтыг “Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт боловсруулах журам”-ын дагуу нэгэн жишигт нийцүүлэн боловсруулах талаар байгууллагын төсвийн захирагч нарт чиглэл өгч, Салбар зөвлөлийн хуралдаанаар боловсролын салбарын 5, эрүүл мэндийн салбарын 5, туслах чиг


⁷ Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой хуваарилах санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий нэгжийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцэд бий болгоно.

үүргийн 6, нарийн мэргэжлийн чиглэлийн 5, нийт 21 төрийн үйлчилгээний албан тушаалын тодорхойлолтын жишгийг боловсруулж, төрийн байгууллагуудад хүргүүлж ажиллажээ.

Аймаг, сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төвийн төсвийн захирагч нарын албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулан, ТА3-д 2019 оны 11 дүгээр сард хүргүүлсэн байна.

Баянхонгор аймаг дахь ТАС3-ийн 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах, зөвшөөрөл авахтай холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хэсгийг ТАС3-ийн даргаар ахлуулсан, 10 хүний бүрэлдэхүүнтэй томилжээ. Тус ажлын хэсэг албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх ажлыг ТА3-өөс өгсөн чиглэлийн дагуу зохион байгуулах үүрэгтэй бөгөөд ажлыг тайлагнах хугацаа болоогүй байна.

ТА3-ийн www.csc.gov.mn цахим хуудаст батлагдсан албан тушаалыг 6 чиглэлийн дагуу 2019 оны 12 дугаар сард байршуулсан боловч байршуулсан зарим албан тушаалын тодорхойлолттой иргэд танилцах боломжгүй, файлыг нээгдэхгүй, баталсан албан тушаалын тодорхойлолтуудыг ямар эх сурвалжаас авах нь тодорхойгүй байна. Иймд ТА3-ийн шийдвэрээр баталсан албан тушаалын тодорхойлолтуудыг зөвлөлийн сайтад бүрэн байршуулах саналыг ҮАГ-т уламжлав.



№	Төрийн албаны нэр	Төрийн албаны зөвлөлийн шийдвэр	Төрийн албаны зөвлөлийн шийдвэр
1	Төрийн албан хаагчийн туслах	2019 он 12 сар 11	Баталсан
2	Төрийн албан хаагчийн туслах	2019 он 12 сар 11	Баталсан
3	Төрийн албан хаагчийн туслах	2019 он 12 сар 11	Баталсан
4	Төрийн албан хаагчийн туслах	2019 он 12 сар 11	Баталсан
5	Төрийн албан хаагчийн туслах	2019 он 12 сар 11	Баталсан
6	Төрийн албан хаагчийн туслах	2019 он 12 сар 11	Баталсан

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудын төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтнуудын албан тушаалын тодорхойлолтыг ТА3-ийн баталсан жишиг албан тушаалын тодорхойлолтыг үндэслэн боловсруулсан хэдий ч “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллаагүй зөрчил нийтлэг байна.

Аудитын илрүүлэлт

- Баянхонгор аймгийн Засаг даргын 2011 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 90 дугаар захирамжаар байгуулагдсан Сум дундын Ойн ангийн дарга, албан хаагчид албан тушаалын тодорхойлолтыг батлуулаагүй ;
- Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсөн байхад албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод албан тушаалын ангилал, зэрэглэл хуучнаараа бичигдсэн;
- Сумдын эрүүл мэндийн төвийн төсвийн захирагч нарын албан тушаалын тодорхойлолтын төслийг ТАС3 боловсруулан, 2019 оны 11 дүгээр сард ТА3-д хүргүүлсэн байна. Гэвч одоо болтол сумдын эрүүл мэндийн төвийн дарга нарын албан тушаалын тодорхойлолт батлагдаж ирээгүйгээс тусгай шалгалтыг зохион байгуулахгүй, аймгийн Засаг даргын тушаалаар томилж байгаа нь Төрийн албаны зөвлөлийн 03 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 6.1⁸-т заасныг зөрчсөн байна.

Дээрх зөрчлүүд нь “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.3⁹, 6.1¹⁰, 6.2¹¹ заалтуудыг зөрчсөн тул аудитаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийж,

⁸ Энэ журмын 4.1, 5.3-т заасан үйл ажиллагааг албан тушаалын тодорхойлолтыг хүлээн авснаас хойш ажлын 15 хоногт багтаан гүйцэтгээнэ
⁹ Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн саналыг авсаны үндсэн дээр томилох эрх бүхий этгээд батална.
¹⁰ Энэ журмын 4.1, 5.3-т заасан үйл ажиллагааг албан тушаалын тодорхойлолтыг хүлээн авснаас хойш ажлын 15 хоногт багтаан гүйцэтгээнэ.
¹¹ Байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан нь тухайн албан тушаалын тодорхойлолтыг албан тушаалд томилогдож буй этгээдэд албан ёсоор танилцуулах үүрэгтэй бөгөөд танилцсан тухай баримтад гарын үсэг зуруулж, хувийн хэрэгт хавсаргана.

Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчлийг арилгах зөвлөмжийг Баянхонгор аймаг дахь ТАСЗ-д хүргүүлэв.

1.3.2 Төрийн албан хаагчийг тогтвор сууршилтай ажиллуулах нийгмийн баталгаа жилээс жилд нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Төрийн албаны цалингийн нэгдсэн системээс аймгийн хэмжээнд 2023 оны 12 дугаар сард олгосон цалингийн мэдээллийг авахад 184 байгууллага 5,593 албан хаагчдад 13,450.1 сая төгрөгийн цалинг олгосон байна.

Хүснэгт 1. ТАЦНС-ээс татсан 2023 оны 12 сард олгосон цалингийн судалгаа (сая.төг)

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр	Байгууллагын тоо	Албан хаагчдын тоо	Олговол зохих цалин /сая төг/
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	3	128	337.5
Барилга, хот байгуулалтын сайд	1	36	183.0
Боловсрол, шинжлэх ухааны сайд	68	2,724	6,023.7
Монгол улсын ерөнхий аудитор	1	13	76.2
Монгол улсын сайд, олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга	1	49	156.5
Монгол улсын шадар сайд	1	20	39.2
Орон нутгийн засаг захиргаа	49	953	2,304.4
Сангийн сайд	1	45	223.5
Соёлын сайд	24	265	574.6
Улсын ерөнхий прокурор	1	22	89.8
Үндэсний статистикийн хорооны дарга	1	5	18.5
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	3	123	399.9
Хууль зүй, дотоод хэргийн сайд	4	245	679.9
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	2	73	247.2
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	1	33	186.5
Эрүүл мэндийн сайд	23	859	1,909.9
Нийт дүн	184	5,593	13,450.1

Эх сурвалж: Төрийн албаны цалингийн нэгдсэн систем

УИХ-ын 1995 оны 73 дугаар тогтоол, 2019 оны 21 дүгээр тогтоолуудаар “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу 2012-2023 онд аймгийн Засаг даргын захирамжаар 476 албан хаагчдад зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон байна.

Хүснэгт 2.Төрийн жинхэнэ албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдлийн судалгаа

Ангилал		2012	2013	2015	2016	2017	2019	2020	2021	2022	2023	НИЙТ ДҮН
Эрхэлсэн түшмэлийн гутгаар			1									1
ахлах түшмэл	тэргүүн	1	1			2	7					11
	дэд			2		1	6					9
	гутгаар		2	1			3	1	3			10
	дөтгөөр	2		3	3	1	10	12	2			33
дэс түшмэл	тэргүүн	4	1	4	4	2	13	2	1		7	38
	дэд	3	4	2	5	1	8	5	6		14	48
	гутгаар		3	1	7	5	21	10	14		7	68
	дөтгөөр	12	8	8	9	14	41	15	9	7	4	127
туслах түшмэл	тэргүүн		1	3	2	3	7					16
	дэд	1	2	4	1	3	9					20
	гутгаар	2	8	10		8	6	5				39
	дөтгөөр	7	15	6	9	7	7	5				56
Нийт		32	46	44	40	47	138	55	35	7	32	476

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын захирамж

Зэрэг дэв олгосон байдлыг аймгийн төвийн төрийн захиргааны байгууллагуудаас түүвэрлэн авч үзэхэд зөрүү гараагүй болно.

Аймгийн хэмжээнд 2023 оны 12 сард 179 төрийн жинхэнэ албан хаагчдад 62.6 сая төгрөгийн цолны нэмэгдэл олгосон бөгөөд зэрэг дэвийн нэмэгдэл давхардуулан олгоогүй байна.

Орон нутгийн нэмэгдлийг олгох төрийн захиргааны 59 байгууллагын 599 албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг 20-80 хувиар тооцож, нийт 227.5 сая төгрөгийг олгосон байна.

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын дагуу 2023 оны 12 дугаар сард 59 төсвийн байгууллагын 599 албан хаагчдад үндсэн цалингийн 20-80 хувиар тооцож 227.5 сая төгрөгийг олгосон байна.

Хүснэгт 3. Орон нутгийн нэмэгдлийн судалгаа (сая төг)

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр	Байгууллагын тоо	Төрийн албан хаагчийн тоо	Орон нутагт ажилласны нэмэгдэл
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	2	16	3.7
Барилга, хот байгуулалтын сайд	1	31	14.0
Боловсрол шинжлэх ухааны сайд	1	14	3.7
Монгол улсын шадар сайд	1	8	1.9
Орон нутгийн засаг захиргаа	43	290	142.1
Сангийн сайд	1	36	9.5
Соёл урлагийн газар	1	6	1.4
Үндэсний статистикийн хорооны дарга	1	5	1.8
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	3	80	19.5
Хууль зүй, дотоод хэргийн сайд	1	34	9.1
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	2	51	12.5
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	1	16	5.3
Эрүүл мэндийн сайд	1	12	3.0
ДҮН	59	599	227.5

Эх сурвалж: Төрийн албаны цалингийн нэгдсэн системээс

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор захиргааны асуудал эрхэлдэг төрийн албан хаагч нарт орон нутгийн нэмэгдлийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгохоор заасан байхад төрийн захиргааны 67 байгууллагаас 59 байгууллагад орон нутгийн нэмэгдлийг олгоу, харин Баянхонгор аймаг дахь Төрийн Аудитын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Шаргалжуут тосгоны Захирагчийн ажлын алба, Баянцагаан сумын ИТХ, Гурванбулаг сумын ИТХ, Шүүх шинжилгээний хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар гэсэн байгууллагууд орон нутгийн нэмэгдэл олгоогүй байна.

Баянхонгор аймгийн Шүүхийн Тамгын газрын 16 шүүгч Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17/57 дугаар тогтоолын 8 дахь заалтад Шүүхийн Тамгын газрын албан хаагчдыг хамруулахгүй байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгож, тус заалтад Шүүхийн Тамгын газрын Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдыг хамруулж, орон нутгийн нэмэгдлийг 2024 оны 01 дүгээр сараас нөхөн олгох шаардлага бүхий захиргааны хэргийн шүүхэд хандсан байна.

Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 111/ШШ2024/0067 дугаар захирамжаар эвлэрлийг батлаж хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Төрийн байгууллагуудад төрийн албан хаагчийг төсвөөс бус санхүүжүүлэн ажиллуулсан тохиолдол байхгүй байна.

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлуулаагүй байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2010 оны 505 дугаар захирамжаар “Баянхонгор аймгийн Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа” дэд хөтөлбөрийг 2010-

2015 онд хэрэгжүүлэхээр баталсан боловч тус дэд хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой материалыг аймгийн ЗДТГ-ын архиваас олдоогүй, 2012 онд “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, сургалт мэдлэг чадварыг бий болгох аймгийн хөтөлбөр”-ийг төрийн байгууллагуудад мөрдүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нэг зорилт болгон тусгаж хэрэгжилтийг тооцон ажилласан гэж тайлагнажээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2017 оны А/75 дугаар тогтоолоор “Аймгийн Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг”-ийг томилсон боловч тухайн ажлын хэсэг нь дэд хөтөлбөр боловсруулж батлуулаагүй байна.

Гэвч тус хөтөлбөрийг батлаагүй байхад Баянхонгор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр заалт оруулж, биелэлтийг тайлагнасан ч 2022- 2024 онд “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталсан 153 байгууллага байна гэж тайлагнасан ч аудитаар байгууллагуудын нэрсийг гаргаж ирүүлээгүй болно.

Төрийн албаны тухай хуулийн 59, 60, 61 дугаар зүйлд заасны дагуу Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2012-2022 оны хавсралт судалгааг жил бүр ТАСЗ нэгтгэж, тайлагнаж ирсэн боловч тайлангийн хавсралтуудыг ТАГ-т ирүүлээгүй ба 2023 оны жилийн эцэс, 2024 оны эхний хагас жилийн байдлаар дараах зардлыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулжээ.

Төрийн байгууллагууд төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн “Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх” зорилтын хүрээнд 3 арга хэмжээг баталж, аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т тайлагнаж иржээ. Тус хэлтсээс ирүүлсэн сүүлийн 4 жилийн байдлаар тус зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг дараах байдлаар үнэлжээ.

Хүснэгт 4.Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх зорилтын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт /оноор, хувьар/

Арга хэмжээ	2020 он	2021 он	2022 он	2023 он	4 жилийн дундаж
1. Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	100	90	100	100	97.5
2. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	0	100	100	100	75
3. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	100	100	100	100	100

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс ирүүлсэн тайлан

Байгууллагын үйл ажиллагаанд 2024 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг авч үзэхэд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын байгууллагуудын дундаж хэрэгжилт 85.1 хувь, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын дундаж хэрэгжилт 75.7 хувь, 20 сумдын ЗДТГ-ын дундаж хэрэгжилт 79.8 хувьтай гарчээ.

Баянхонгор аймаг дахь ТАСЗ-ийн 2023 оны тайлангийн хавсралт мэдээллийн тоог мянгачилсан, задгай хэлбэрээр ойлгомжгүй нэгтгэсэн, ажиллаж байгаа албан хаагчийг тэтгэвэрт гарснаар тайлагнасан, зарим байгууллагын нэрийг бичээгүй зэргээр бэлтгэсэн нь тайлагналын үнэн зөв байдал хангагдахгүй байгаа нь ТАЗ-ийн хэмжээнд мэдээлэл буруу нэгтгэгдэх эрдсэлтэй байна. Иймд цаашид тайлангийн үнэн зөв байдалд тавих хяналтыг сайжруулах зөвлөмжийг ТАСЗ-ийн даргад хүргүүлэв.

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчдад орон сууц, хашаа байшин худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх баталж, журмын дагуу орон нутгийн төсвөөс 2012, 2020 онуудад нийт 972.0 сая төгрөгийг 188 төрийн албан хаагчдын нийгмийн баталгааны зардалд олгосон нь төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай, үр дүнтэй ажиллах хөшүүргийг бий болгосон байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2012 оны 04 дугаар 09-ны өдрийн 154 дугаар захирамжаар Төрийн зарим албан хаагчид Банкнаас орон сууцны зээл авах болзол шаардлагыг хангахгүй байгаа бодит нөхцлийг харгалзан үзээд орон сууцны байрыг худалдан авахад 32 албан хаагчдад тус бүр 6.0 сая төгрөг нийт 192.0 сая төгрөгийг олгосон;
- Аймгийн Засаг даргын 2012 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 292 дугаар захирамжаар 56 төрийн албан хаагчдад тус 5 сая нийт 280.0 сая төгрөгийг олгосон;
- Аймгийн ИТХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчдад орон сууц, хашаа байшин худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг үндэслэн аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 344 дугаар захирамжаар төрийн албан хаагчдад орон сууц, хашаа байшин худалдан авахад зориулж 100 төрийн албан хаагчдад 500.0 сая төгрөгийг олгосон байна

Хоолны хөнгөлөлтийг 2023 оны 12 сард төсөвт 184 байгууллагаас 70 байгууллага олгохдоо төсвөөс шалтгаалан өдөрт 1.0-20.0 мянган төгрөгийн хооронд 281.7 сая төгрөгийг олгосон байна.

ЕБС-ийн багш ажилтанд 2019-2023 онд өндөр настаны тэтгэвэр гаргахад олгох нэг удаагийн тэтгэмжид 192 хүнд 3,712.0 сая, 6 сар тутамд олгох тэтгэмжид 939 хүнд 4,368.4 сая, СӨБ-ийн багш, ажилтанд өндөр настаны тэтгэвэр гаргахад олгох нэг удаагийн тэтгэмжид 75 хүнд 4,368.4 сая, 6 сар тутамд олгох тэтгэмжид 313 хүнд 1,593.6 сая, Эрүүл мэндийн төвийн багш ажилтанд өндөр настаны тэтгэвэр гаргахад олгох нэг удаагийн тэтгэмжид 65 хүнд 1,213.7 сая, 6 сард олгох нэг удаагийн тэтгэмжид 762 хүнд 2,115.5 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Хүснэгт 5.Боловсрол, Эрүүл мэндийн салбарын тэтгэвэр тэтгэмжийн судалгаа (сая төг)

Он	ЕБС				Цэцэрлэг				Эрүүл мэндийн төв			
	Тэтгэвэр		Тэтгэмж		Тэтгэвэр		Тэтгэмж		Тэтгэвэр		Тэтгэмж	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
2019	34	599.4	175	762.9	6	99.9	25	249.6	6	113.8	101	228.2
2020	29	557.9	140	584.6	19	236.5	41	192.0	5	64.0	101	279.0
2021	38	684.6	141	652.0	13	194.6	51	221.4	18	354.7	219	835.5
2022	37	805.9	315	1,510.2	10	175.6	97	460.1	15	281.8	212	394.9
2023	54	1,064.4	168	858.8	27	495.4	99	470.5	21	399.5	129	378.0
ДҮН	192	3,712.0	939	4,368.4	75	1,201.9	313	1,593.6	65	1,213.7	762	2,115.5

Эх сурвалж: Боловсрол, Эрүүл мэндийн газрын төсвийн мэргэжилтнээс ирүүлсэн

УИХ-ын “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр тогтоолын 4-т “төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оны төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх”, 5-т “төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах” шийдвэр гарч, үүнтэй холбоотойгоор төрийн албан хаагчдад зэрэг, дэв олгох буюу зэрэг дэв ахиулах шийдвэрийг 2017 оны 05 дугаар сараас 2019 он дуустал гаргаагүй байна.

Төрийн байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдуулан мөрдсөн

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар шинээр ажлын чиг үүрэг бүхий, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр настны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх, салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж сургалт, семинар хурал зөвлөгөөн зэрэг дотоод албан томилолтын зардлыг хэмнэх, гар утасны зардал, ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсвэл өөрийн болон эхнэр (нөхөр)-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих ирэх замын зардал зэрэг зардлуудыг хязгаарласан байна.

1.3.3. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэхгүйгээс төрийн байгууллагад сул орон тооны мэдээллийг хуульд заасан хугацаанд ТАСЗ-д ирүүлэхгүйгээс сул орон тоог нөхөхөд цаг хугацаа алдах, орон тоо нөхөгдөхгүй байх эрсдэлийг дагуулж байна.

Иймд төрийн байгууллагуудад гарсан сул орон тоо гарсан тухай бүр холбогдох мэдээллийг ХНУСТ цахим системээс Төрийн албаны салбар зөвлөлд мэдээлэл ирэх зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, программын хөгжүүлэлтийг хийх замаар тус зөрчлийг давтан гаргахгүй байх саналыг ҮАГ-аар дамжуулан ТА3-д хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт

- Баянхонгор аймгийн Сум дундын Ойн анги, “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын дарга нарыг төрийн үйлчилгээний удирдах ажилтны сонгон шалгаруулалтад ороогүй байхад аймгийн Засаг даргын захирамжаар томилсон байна.

Дээрх зөрчил нь ТА3-ийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 1.4.2¹², ТА3-ийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 1.5¹³ заалтыг зөрчсөн тул зөрчлийг арилгах зөвлөмжийг Баянхонгор аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4¹⁴, ТА3-ийн 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5¹⁵-т заасны дагуу сул орон тооны шалгаруулалтыг Баянхонгор аймаг дахь ТАСЗ холбогдох эрх зүйн актын дагуу зохион байгуулсан байна.

Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг 1995-2012 онд цаасан суурьтай, тусгай картаар явуулж байсныг 2012 оноос цахим хэлбэрт шат дараатай шилжүүлэн, 2021 оноос сонгон шалгаруулалтыг бүрэн цахимжуулсан байна.

Ингэснээр хөдлөнгийн нөлөөллөөс ангид, хүний оролцоо багасгаж, ил тод, нээлттэй явуулах боломжийг бүрдүүлж, иргэд Төрийн албаны зөвлөлийн цахим хуудаснаас мэдээллийг авах бүрэн боломжтой болжээ.

Нутгийн захиргааны байгууллагын сул орон тооны захиалгыг байгууллагуудаас ирүүлсэн албан бичиг, сул орон тооноос чөлөөлсөн албан хаагчийн тушаал, албан тушаалын

¹² Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх бусад төсвийн байгууллага (хүн эмнэлэг, театр, чуулга, музей, соёлын төв, номын сан зэрэг бусад байгууллага)-ын дарга (захирал, эрхлэгч)-ын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг тухайн аймаг, нийслэл дэх Салбар зөвлөл,

¹³ Албан тушаалын тодорхойлолтыг байгууллагын чиг үүрэг, хууль тогтоомжийн дагуу боловсруулсан стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын байрны шинжилгээнд үндэслэн боловсруулна.

¹⁴ Энэ хуулийн 33.2-т заасан ерөнхий болон тусгай шалгалтыг төрийн албаны төв байгууллага зохион байгуулна.

¹⁵ Төрийн албаны шалгалт зохион байгуулах хүрээнд:

тодорхойлолтыг үндэслэн мэдээллийг нэгтгэн, шалгалт эхлэхээс өмнө Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn болон Баянхонгор аймгийн www.bayankhongor.gov.mn Цахим хуудас, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээллийг иргэдэд тухай бүрд хүргэсэн байна.

Энэ нь ТАЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.2¹⁶-т заасны дагуу ХНУМТ цахим системд сул орон тооны мэдээллийг оруулах асуудал хангалтгүй байна.

Иймд цаашид төсөвт байгууллагууд журмын заалтыг бүрэн мөрдөж, мэдээллийг иргэд, албан хаагчдад тухай бүрд шуурхай хүргэх шаардлагатай байна.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2¹⁷, журмын 4.3¹⁸-т заасан хугацаанд сул орон тоо гарсан талаарх болон сонгон шалгаруулалтын захиалгыг ирүүлээгүй, сул орон тоог явуулахад шаардлагатай баримт материалыг ТАСЗ-д бүрэн ирүүлээгүй, ТАСЗ сул орон тоо гарсныг нотлох шийдвэрийг бүрдүүлэн ТАЗ-д илгээж хянуулж байгаа зэргээс цаг хугацаа алдах эрсдэлтэй байна.

Сул орон тоог нөөцөд бүртгэгдсэн болон нээлтэй сонгон шалгаруулалтаар сонгогдсон албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан иргэдээс нөхөн томилж иржээ.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийг боловсролын гэрчилгээтэй тулгахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

Аудитын илрүүлэлт

- Баянхонгор сумын ЗДТГ-ын дотоод сүлжээ хариуцсан ажилтан нь албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжилд нийцээгүй;
- Баянхонгор сумын ЗДТГ-ын газар зохион байгуулагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан архитектур биш албан хаагчийг ажиллуулсан;
- Өлзийт сумын Цэцэрлэгийн хөгжмийн багшаар бүжгийн багш мэргэжилтэй хүн ажиллаж байгаа;
- Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолтод боловсролын шинжлэх ухаан, багш, нийгмийн хамгаалал, нийгмийн ажил зэрэг мэргэжил заасан байхад социологич мэргэжилтэй хүн ажиллаж байгаа;
- Өлзийт сумын ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн бизнесийн удирдлагын мэргэжилтэй байгаа нь албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжилд нийцээгүй;
- Өлзийт сумын ЗДТГ-ын архив бичгийн хэргийн ажилтан цэцэрлэгийн багш мэргэжилтэй;
- Эрдэнэцогт сумын төрийн сангийн мэргэжилтэн статистик мэргэжилтэй байгаа нь тус албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжилд нийцээгүй;
- Эрдэнэцогт сумын Соёлын төвийн бүжгийн багш болон хөгжмийн багшаар ажиллаж байгаа 2 албан хаагч нь албан тушаалын тодорхойлолтын албан тушаалд тавигдах тусгай шаардлагад заасан мэргэжлийг эзэмшээгүй;
- Баян-Овоо сумын Соёлын төвийн өвийн ажилтны газар зохион байгуулагч инженер мэргэжилтэй байгаа нь албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжилд нийцээгүй;

¹⁶ Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтан Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сул орон тоог олон нийтэд мэдээлэх, төрийн жинхэнэ албан хаагч төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах боломжийг хангах үүднээс уг албан тушаалд ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд 5-аас доошгүй хоногийн хугацаанд Зөвлөлийн цахим хуудас, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системээр мэдээлнэ. Төрийн жинхэнэ албан хаагч тухайн албан тушаалын тусгай шаардлагыг хангаж буй тохиолдолд адил төрлийн албан тушаалын адил ангилалд шилжүүлэн ажиллуулахдаа тусгай шалгалтгүйгээр шууд томилно.

¹⁷ Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.

¹⁸ Энэ журмын 4.2-т заасны дагуу нөхөгдөөгүй тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарснаас хойш 21 хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулах захиалгыг Зөвлөл, Салбар зөвлөлд харьяаллын дагуу ирүүлэх бөгөөд дор дурдсан баримт бичгийг хавсаргана: 4.3.1.албан тушаалын тодорхойлолт; 4.3.2.тухайн албан тушаалын сул орон тоо гарсныг нотлох шийдвэр.

Албан тушаалын тодорхойлолтод тохирохгүй мэргэжлийн бус хүн ажиллуулж байгаа шалтгааныг шалгагдагч байгууллагуудаас ирүүлэхдээ орон нутагт мэргэжлийн хүн дутагдалтай гэсэн тайлбарыг өгч байгаа бөгөөд Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад хийж, зөрчлийг арилгах зөвлөмжийг Баянхонгор аймаг дахь ТАСЗ-д хүргүүлэв.

Төрийн албаны тухай хуульд 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн 23.4 дэх хэсгийг үндэслэн Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор “Төрийн улс төрийн албан тушаалд ажилласан хугацааг төрийн захиргааны албан тушаалын зохих ангилалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцох журам”-ын дагуу Баянхонгор аймаг дахь ТАСЗ-ийн тогтоолоор 2023 онд 6 иргэний улс төрийн албан тушаалд ажилласан хугацааг 2 жил 7 сараас 10 жил 7 сарын хугацаагаар дүйцүүлэн тооцож баталгаажуулсан байна.

Дээрх зохицуулалтыг хийснээр төрийн захиргааны албан тушаалд ажиллах хүний нөөц, ур чадварын өрсөлдөөн нэмэгдэн, сул орон тооны нөхөлтөд дэмжлэг үзүүлэх, иргэдийн төрийн алба хаах адил тэгш боломжийг олгосон байна.

1.3.4 Төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд учруулсан хохирлыг буруутай шийдвэр гаргасан албан хаагчаар төлүүлэх арга хэмжээг хангалттай авч ажиллаагүй байна.

Төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсантай холбоотой Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2012-2024 онд 96 нэхэмжлэл ирснээс 95 албан хаагчийн эрх зөрчигдөж хууль бусаар томилогдож, чөлөөлөгдсөн гэж үзэж нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангасан, 1 нэхэмжлэлийг шүүх хуралдааны явцад хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хүлээн зөвшөөрч талууд эвлэрлийн гэрээ байгуулан шийдвэрлэсэн байна.

ТАЗ-өөс Баянхонгор аймагт 2023 онд зохион байгуулсан төлөвлөгөөт хяналт шалгалтаар Төрийн захиргааны байгууллагад Төрийн албаны хууль, тогтоомж зөрчиж, төрийн жинхэнэ албан тушаалд зөрчилтэй томилсон 56 томилгоог илрүүлсэн, эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн албан хаагчдын талаарх мэдээллийг шалган, ял шийтгүүлж байсан 18 албан хаагчдаас 15 албан хаагчид ял шийтгүүлсэн хугацаанаас хамааран эрх зүйн байдлыг дордуулахгүй гэж үзсэн ба 3 албан хаагчийн хувьд ял шийтгүүлсэн цаг хугацааг харгалзан албан тушаалаас нь халах үндэслэл болно гэж үзсэн байна. Эдгээр албан хаагчдаас нэг албан хаагч нь тухайн албан тушаалаасаа чөлөөлөгдөж, харин 2 албан хаагч нь одоог болтол төрийн албанд ажиллаж байна. ТАЗ-ийн 2024 оны 171 дүгээр тогтоолд өмнөх оны 482 дугаар тогтоолоор өгсөн зөвлөмжийн хугацааг хэтрүүлсэн томилгооны зөрчилтэй 23 албан хаагчдад олгосон цалин хөлсийг төрд хохирол учруулсан гэж үзэж холбогдох томилсон буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэх гаргах талаар тусгасан байна.

Баянхонгор аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс 2021 онд “Төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийн хүрээнд сумдын төсөвт байгууллагууд болон аймгийн төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөх туслах ажил”-ыг зохион байгуулсан ба хяналт шалгалтаар холбогдох Төрийн үйлчилгээний байгууллагын дарга, удирдлага төрийн албаны тусгай шалгалт өгөөгүй, албан тушаалын тодорхойлолтын мэргэжлийн шаардлагад нийцээгүй иргэнийг томилсон зэрэг алдаа зөрчил илрүүлэн ажилласан байна. Тухайлбал: Аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын сул ажлын байрны захиалгыг Баянхонгор аймаг дахь ТАСЗ-д 2021 онд хүргүүлж, төрийн албаны ерөнхий

нөөцөд бүртгэгдсэн ч аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, Тэргүүлэгчийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4, 37.1.5, 39¹⁹ дүгээр зүйлийн 39.1.5²⁰ дахь заалтыг тус тус зөрчсөн гэж үзсэн байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланд 2016-2019 онд ТАЗ-д ирүүлсэн өргөдөл гомдлын агуулгаар нь харахад сонгууль болсон жилд бүтцийн өөрчлөлтөөр албан тушаалаас халагдсантай холбоотой өргөдөл, гомдлын тоо огцом өссөн талаар тусгасан байна.

Үүнээс харахад Төрийн албан хаагчийг улс төрийн нөлөөнөөс шалтгаалан төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас төрд хохирол учирсан байна.

Авлигатай тэмцэх “Шүүр” ажиллагааг 2023 онд хэрэгжүүлэхээр Засгийн газрын хэрэг эрхлэх газраас ирүүлсэн чиглэлийн дагуу аймгийн Засаг даргын эрхлэх салбарын агентлаг, харьяа сум, байгууллагын хэмжээнд хийсэн хяналт шалгалтаар 15 байгууллагын 31 албан хаагчийн зөрчилтэй томилгоо илрүүлсэн байна. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил бүрэн хэрэгжээгүй байна.

Төрийн албан хаагчийн эрх зөрчигдсөн маргаан, Хэргийг урьдчилан шийдвэрлэх, дэд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах талаар аудитын хамрах хугацаанд үйлчилж байсан эрх зүйн орчны талаар авч үзвэл Хэргийг урьдчилан шийдвэрлэх, дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах талаар 2002 оны Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгасан байсан боловч 2016 оноос мөрдөгдсөн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой тусгаагүй байна. 2019 оноос мөрдөгдөж эхэлсэн Төрийн албаны тухай хуулийн хорин хоёрдугаар бүлэгт, Захиргааны ерөнхий хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт тус тус дээд шатны захиргааны байгууллагад, эсхүл гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагад өргөдөл гомдол гаргах, урьдчилан шийдвэрлэх ажиллагааны талаар тус тус тусгасан байна.

Төрийн албаны тухай хуульд 2019 онд нэмэлт, өөрчлөлт орсноор төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагчийн хооронд төрийн албатай холбогдуулан гарсан өргөдөл, гомдол маргааныг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргадаг ба хэргийг урьдчилан шийдвэрлэх журмын дагуу ТАЗ-д ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэж жил бүрийн үйл ажиллагааны тайландаа маргаан шийдвэрлэлтийн талаар тодорхой тусгасан байна.

Баянхонгор аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооноос ирүүлсэн мэдээллээр 2013-2024 онд 441 хүний өргөдөл, гомдлыг хэлэлцэж, 322 зөвлөмж гаргасан байна. Ирсэн өргөдлийг ангилж үзвэл ажлаас халагдсан гомдол 101, өөр ажилд хууль бусаар шилжүүлсэн 19, цалин хөлсний маргаан 285 бусад маргаан 36 байгаа ба хэлэлцсэн өргөдлийн 94.1 хувь нь өргөдөл гаргасан ажилтны талд шийдвэрлэн ажилласан байна.

¹⁹ 37.1.4.улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам, эвсэл, хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх;
37.1.5.хэрэв улс төрийн намын гишүүн бол намын гишүүнээс түдгэлзэж, тухайн төрийн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш долоо хоногийн дотор байгууллагын захиргаа болон харьяалах намдаа бичгээр албан ёсоор мэдэгдэх;

²⁰ 39.1.5.улс төрийн намын гишүүн байх, улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн намын дэргэдэх төрийн бус байгууллага болон шашны байгууллагын үйл ажиллагаанд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа хэлбэрээр оролцох;

Төрийн албаны тухай хуулийн 50²¹ дугаар зүйл, ЗЕХ-ийн 103²² дугаар зүйлд зааснаар хууль бус шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг Дотоод аудитын нэгж, Төрийн албаны зөвлөл, дотоод аудитын нэгжгүй бол Төрийн аудитын байгууллага хэрэгжилтийг хангах үүрэгтэй байдаг.

Баянхонгор аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүх болон Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсан гэж үзэж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд ирүүлсэн судалгаа болон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ЗЕХ-ын 103 дугаар зүйлд холбогдох шийдвэрийн нэгтгэлийг үндэслэн Баянхонгор аймгийн хэмжээнд 2016-2023 онд хууль бус шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн 79 албан хаагчдад олгосон нөхөн төлбөр төрд учирсан хохирлын хэмжээ 373.8 сая төгрөг байна.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын санхүүгийн тайлангийн 2019-2024 оны аудитаар төрд учирсан 186.1 сая төгрөгийн хохирлыг 31 буруутай албан тушаалтнаар төлүүлж зөрчлийг арилгах албан шаардлагыг Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба болон төсвийн шууд захирагч нарт хүргүүлэн ажилласан.

Санхүүгийн хяналт дотоод аудитын алба нь 2016-2021 онд хууль бус шийдвэрийн улмаас төрд учирсан 57 албан хаагчийн 279.2 сая төгрөгийн хохирлыг бүртгэн мэдээллийн сан үүсгэн байна.

Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас аймгийн Прокурорын газарт 19.7 сая төгрөгийн 5, Боловсрол шинжлэх ухааны яамны хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт 118.6 сая төгрөгийн 20, Соёлын яамны хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт 4.3 сая төгрөгийн 4, ТАСЗ-д 59.3 сая төгрөгийн 6 буруутай албан тушаалтны холбогдох баримтыг тус тус хүргүүлэн ажилласан байна.

ҮАГ-т уламжлах

- Аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 24 албан хаагчийн 122.9 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх талаар 2022 онд холбогдох яамдад албан бичгээр хүргүүлсэн боловч авсан арга хэмжээ, шийдвэрлэгдсэн талаар эргэж ямар нэгэн хариу өгөөгүй болно. Иймд аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас ТАЗ болон яамдын дотоод аудитын газруудад хүргүүлсэн төрд учирсан хохирлын үүргийн хэрэгжилтийн хүрээнд гаргасан шийдвэр, авсан арга хэмжээний талаар хариу өгч уялдаа холбоотой ажиллах саналыг ҮАГ-аар дамжуулан уламжлах нь зүйтэй байна.

Төрийн албанаас хууль бусаар чөлөөлөгдсөн 79 албан хаагчийн 373.8 сая төгрөгийн хохирлоос 27 хувийг буюу 27 албан хаагчийн 134.3 сая төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн байна. /Төрд учирсан хохиролтой холбоотой судалгааг хавсралтаар оруулав.

Үүнээс Хууль зүйн дотоод хэргийн сайдын төсөвт тусгасан мөнгөн хөрөнгөөс 2018 оны А/190, 2020 оны А/80 дугаар тушаалаар холбогдох 44.5 сая төгрөгийн 7 албан хаагчийн нөхөн төлөх олговрыг шийдвэрлэсэн байна.

Захиргааны Ерөнхий хууль болон Төрийн албаны тухай хуульд 2022 онд тус тус нэмэлт өөрчлөлт орсноор иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага гэм буруутай этгээдээр буцааж төлүүлэх талаар тусгасан байна. Үүнтэй холбогдуулан Баянхонгор аймгийн Иргэний хэргийн анхан шатны

²¹ 50 дугаар зүйл.Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих

²² 103 дугаар зүйл.Захиргааны байгууллага хохирлоо барагдуулах

шүүхэд 2021-2023 онд нийт 19 нэхэмжлэл ирсэн ба үүнээс аймгийн Прокурорын газраас 16, Төрийн албаны зөвлөлөөс 2, Иргэний нисэхийн Ерөнхий газраас 1 нэхэмжлэлийг тус тус гаргасан байна.

Баянхонгор аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс 8 хэргийг нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүчингүй болгон шийдвэрлэсэн бол 8 хэргийг хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч хэргийг хэрэгсэхгүй болсонд тооцсон, 3 хэргийг нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж шийдвэрлэсэн байна.

Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүчингүй болгож шийдвэрлэсэн 8 хэргийн тухайд Төрийн байгууллагаас холбогдох чиг үүргээ хэрэгжүүлээгүй, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх талаар хуульд заасан журмыг нэхэмжлэгч зөрчсөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар түүний хүсэлтээр аймгийн Прокурорын газар нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогч этгээд байх боломжгүй гэж үзсэн байна.

Хуульд буруутай этгээдээр төрд учирсан хохирлыг нөхөн гаргуулах чиглэлээр Төрийн албаны зөвлөл Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Прокурорын газар Прокурорын тухай хуулийн 41²³ дүгээр зүйл, Төрийн аудит болон дотоод аудитын нэгж Захиргааны ерөнхий хуулийн 103²⁴ дугаар зүйлд заасныг дагуу төрийг төлөөлөн Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь хэсэгт заасны дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхтэй байдаг.

Шүүхээс ИХШХШТ хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д зааснаар иргэний хэргийн шүүх нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.3 дахь хэсэгт төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлж гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг нөхөн төлүүлэхээр асуудалд аудит хийх бүрэн эрхийг олгосон зохицуулалт гэж үзэн Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар түүний хүсэлтээр аймгийн Прокурорын газар нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогч этгээд байх боломжгүй гэж шийдвэрлэсэн тохиолдол цөөнгүй байгаагаас төр хохирлоо барагдуулах ажиллагаа саатсан байна.

1.3.5. Баянхонгор аймаг дахь ТАСЗ-ийн ХНУМТ цахим системд төрийн албан хаагчийн тоон мэдээлэл үнэн зөв бүртгэгдээгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”-ын дагуу Төрийн албаны зөвлөл” Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийг ашиглаж байна.

Баянхонгор аймаг дахь ТАСЗ-ийн ашиглаж байгаа төрийн албаны “ХНУМТ” цахим системд 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 175 төрийн байгууллагын 5,423 төрийн албан хаагч бүртгэгдсэн ба үүнээс 1,526 эрэгтэй, 3,897 эмэгтэй төрийн албан хаагч байна.

²³ 41 дүгээр зүйл.Прокурорын нэхэмжлэл, тайлбар, гомдол

²⁴ 103 дугаар зүйл.Захиргааны байгууллага хохирлоо барагдуулах

Хүснэгт 6. ХНУМТ цахим системд оруулсан мэдээлэл

Төрийн байгууллага	Байгууллагын тоо	Төрийн албан хаагчийн тоо	Хүйс	
			эр	эм
ЗДТГ	21	629	324	305
ИТХ	21	266	172	94
Эрүүл мэндийн төв	21	877	142	735
ЕБС	30	1753	368	1385
СӨБ	36	1052	171	881
Соёлын төв	19	150	49	101
Бусад төрийн байгууллага	27	696	300	396
Нийт дүн	175	5423	1526	3897

Эх сурвалж: ХНУМТ цахим систем

Дээрх мэдээллийг Төрийн албаны цалингийн нэгдсэн системд 2023 оны 12 сард олгосон цалингийн мэдээлэлтэй тулгахад 184 байгууллага 5,593 хүнд цалин олгосон нь босоо бүтэцтэй 9 байгууллагын мэдээлэл харьяа ТЕЗ-ийн ХНУМТ цахим системд нэгтгэгддэгтэй холбоотой байна.

ТАСЗ-ийн 2021 оны 08 дугаар тогтоолоор баталсан удирдамжийн дагуу харьяа 179 байгууллагуудын Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөлтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу 4 шалгуур үзүүлэлтээр үнэлжээ. Үүнээс нийт байгууллагын 37.4 хувь буюу 67 байгууллага нь нууцлалыг бүрэн хангаагүй, 39.8 хувь 66 байгууллага нь хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөнд гарсан өөрчлөлт, хөдөлгөөнийг тухай бүрд хийгээгүй, 45.2 хувь буюу 81 байгууллага нь мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулаагүй байна.

Үүнээс хойших хугацаанд ХНУМТ цахим системд хяналт шалгалт хийгээгүй бөгөөд аудитаар тус системтэй холбоотой дараах нийтлэг зөрчил байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт

- ХНУТС цахим системд мэдээллийг хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагч хариуцахаар байхад сумдын төсөвт байгууллагын нягтлан бодогч нар мэдээллийг өөрсдөө оруулж байгаа;
- Төрийн албаны ХНУМТ цахим системээс мэдээллийг дурын цаглабараар татаж ашиглах боломжгүй;
- Албан хаагчдын улсын болон төрийн байгууллагад ажилласан жилийг үнэн зөв оруулсан эсэхэд мэргэжлийн байгууллага хяналт тавиагүйгээс тус мэдээлэл зөрүүтэй байгаа;
- Тэтгэвэрт гарсан, шилжсэн, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын мэдээллийг оруулаагүйгээс ХНУМТ системд бүртгэлтэй байгаа;
- 1995-2000 оны нөхөн тооцох хугацааны Нийгмийн даатгалын төлсөн хугацаа, хувийн байгууллагад ажилласан хугацааг төрд ажилласан хугацаанд оруулж тооцсоноос төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү олгосон;
- Системийн гацалт их, тайлангууд татагддаггүй, хүний нөөцийн нас, хүйс зэргийг агуулсан судалгаа, тайлангууд татагддаггүй, албан тушаалын тодорхойлолт, мэргэжил мэдлэг дээшлүүлсэн гэрчилгээ зэргийг гараас шивж оруулдаг нь механик ажиллагаа ихтэй
- 2020 оны ТАСЗ тайлан /ХНУТС цахим системд байгууллагуудын тайланг нэгтгэх цэс байхгүйгээс хавсралтаар бэлтгэж байгаа мэдээллийг байгууллагуудаас гаргуулан авч нэгтгэж байгаа нь цаг хугацаа их шаардсанаас гадна мэдээллийг зөрүүтэй нэгтгэхэд хүргэж байгаа тул системийн хөгжүүлэлтийг сайжруулах шаардлагатай тул тус асуудлыг УАГ-аар дамжуулан уламжлав.

Иймд төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын ХНУМТ цахим системд мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулж байгаад хяналт тавьж ажиллах зөвлөмжийг Баянхонгор аймаг дахь ТАСЗ-д хүргүүлж, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар эрсдэл болгон авч үзэхээр шийдвэрлэв.

Баянхонгор аймгийн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/114 дүгээр захирамжаар “Хууль тогтоолын хэрэгжилтийг шалгах ажлын хэсэг”-ийг аймгийн СХДАА-ны даргаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Тус ажлын хэсэг аймгийн төвийн 58 төрийн байгууллагуудын 2023 оны 01, 02 дугаар сарын “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд албан хаагчдын цалин хөлсний тогтоолтыг шалгахад 49 байгууллагын 278 албан хаагчийн ажилласан жилийг илүү тооцсон, 144 албан хаагчийн ажилласан жилийг дутуу тооцсон зөрчил илрүүлжээ. Баянхонгор аймгийн СХДАА-ны 07 дугаартай зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны дотор тооцохоор заажээ.

БҮЛЭГ 2. ИРГЭД, ОЛОН НИЙТЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛД ҮНДЭСЛЭН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ, ЦАХИМ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ НЭВТРҮҮЛЭХЭД ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫГ СУРГАЖ, ЧАДВАРЖУУЛАХ БАЙДАЛ ДУТМАГ БАЙНА.

2.1. Цахимжсан, түргэн шуурхай, хүртээмжтэй төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд төрийн албан хаагчдыг цахим хэрэглээний мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд хүргэж байна.

2.1.1 Төрийн албан хаагчдыг орон зайнаас үл хамааран сургаж байгаа боловч Удирдлагын академийн сургалтад 2019-2023 онд суралцсан нийт суралцагчийн 19.5 хувь буюу 37 албан хаагч сургалтад хамрагдаж төгсөөгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйл, Засгийн 2019 оны 299 дүгээр тогтоолоор баталсан “Сургалтын агуулга, хөтөлбөр батлах тухай”-д заасны дагуу Удирдлагын акедамийн сургалтын албанаас ирүүлсэн судалгаанаас харахад багц сжргалтад 2019-2024 онд улсын төсвөөс 225, төлбөртэй сургалтад 56 албан хаагч сургалтад бүртгүүлснээс 200 албан хаагч сурч төгссөн 81 албан хаагч сурч төгсөөгүй байна.

Удирдлагын акедамийн сургалтад хамрагдаж төгссөн 200 албан хаагчаас 25 албан хаагч дунд шатны сургалтад сургалтад, 48 албан хаагч дунд шатны давтан сургалтад, 119 албан хаагч ахлах түшмэлийн сургалтад, 8 албан хаагч эрхэлсэн түшмэлийн сургалтад хамрагдаж төгссөн байна

Хүснэгт 7. Удирдлагын академийн сургалтад хамрагдсан албан хаагчийн судалгаа

Сургалтын нэр	2019	2020	2021	2022	2023	2024	нийт дүн
Дунд шатны		13	13	9	11	11	57
Улсын төсөвт		13	13	9	11	11	57
Сурч буй		2	9	2	10	9	32
Төгссөн		11	4	7	1	2	25
Ахлах түшмэл	62	6	5	26	25	12	136
Төлбөрт	1	2		19	18	6	46
Сурч буй				3	2	5	10
Төгссөн	1	2		16	16	1	36
Улсын төсөвт	61	4	5	7	7	6	90
Сурч буй			1	1	1	4	7
Төгссөн	61	4	4	6	6	2	83
Дунд шатны давтан		11	16	9	18	21	75
Төлбөрт						6	6
Сурч буй						6	6
Улсын төсөвт		11	16	9	18	15	69
Сурч буй			2	4	3	12	21
Төгссөн		11	14	5	15	3	48
Эрхэлсэн түшмэл	2	2	3	2	1	3	13
Төлбөрт			1	1		2	4
Сурч буй						2	2
Төгссөн			1	1			2
Улсын төсөвт	2	2	2	1	1	1	9
Сурч буй			2			1	3
Төгссөн	2	2		1	1		6
нийт	64	32	37	46	55	47	281

Эх сурвалж: Удирдлагын академийн сургалтын албаны мэдээлэл

Удирдлагын акедакийн багц сургалтад 2019-2023 онд улсын төсвөөс 189 албан хаагч сургалтад бүртгүүлснээс 152 албан хаагч төгссөн, 37 албан хаагч төгсөөгүй байна.

Хүснэгт 8. Удирдлагын акадекийн сургалтад хамрагдсан албан хаагчийн судалгаа

Сургалтын нэр	2020	2021	2022	2023	нийт дүн
Дунд	2	9	2	10	23
Ахлах түшмэл		1	1	1	3
Дунд шатны давтан		2	4	3	9
Эрхэлсэн түшмэл		2			2
нийт дүн	2	14	7	14	37

Эх сурвалж: Удирдлагын акадекийн сургалтын албаны мэдээлэл

Удирдлагын акедакийн багц сургалтад 2019-2023 онд улсын төсвөөс 189 албан хаагч сургалтад бүртгүүлснээс 152 албан хаагч төгссөн, 37 албан хаагч сурч буй төгсөөгүй нь албан хаагчид ажлаас гарсан, тэтгэвэрт гарсан, төрийн үйлчилгээний албан хаагч болсонтой холбоотой, зарим албан хаагчид өөрийн зардлаар нөхөн суралцаж байна. Иймд улсын төсвийн санхүүжилтээр Удирдлагын акадекийн сургалтад хамрагдаж буй албан хаагчтай сургалтын гэрээг байгуулж, төгсөөгүй тохиолдолд зардлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын даргад хүргүүлэв.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын боловсруулсан “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2023-2026” төсөлд Төрийн албаны тухай хуулийн 55.3, 38.1.9-т заасны дагуу албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад үе шаттайгаар хамруулах, ажлын байранд нь мэргэшүүлэх хийж, хэрэгжилтийг хангах үүднээс аймгийн 181 төрийн байгууллагын 45.3 хувь буюу 82 байгууллага нь албан хаагчдын чадавхжуулах хөтөлбөрийг батлан хэрэгжилтийг хангах ажиллаж байна гэсэн боловч 82 байгууллагын нэрсийг ЗДТГ, ТАСЗ-өөс удаа дараа шаардсан хэдий ч ТАГ-т гаргаж ирүүлээгүй болно.

Төрийн байгууллагууд төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн “Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх” зорилтын хүрээнд 3 арга хэмжээг баталж, аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т тайлагнаж иржээ. Тус хэлтсээс ирүүлсэн сүүлийн 4 жилийн байдлаар тус зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг дараах байдлаар үнэлжээ.

Хүснэгт 9. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхижүүлэх зорилтын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт /оноор, хувиар/

Арга хэмжээ	2020 он	2021 он	2022 он	2023 он	4 жилийн дундаж
1. Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	100	90	100	100	97.5
2. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	0	100	100	100	75
3. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	100	100	100	100	100

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс ирүүлсэн тайлан

Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлийн жилийн эцсийн тайланд байгууллага бүрийн сургалт, суралцсан албан хаагчийн тоог нэгтгэж, ТАЗ-д тайлагнасан байна.

Дэлхий дахинд гарсан Ковид 19 цар тахлын нөхцөл байдал үүссэнээс шалтгаалан гадаад сургалт явуулаагүй, дотоод сургалтын үйл ажиллагааг хязгаарласан байна.

Төрийн байгууллагуудын баталсан сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт хэрэгжүүлэх сургалтад шаардагдах санхүүжилтийн дүн, эх үүсвэрийг тусгадаггүй, төрийн байгууллагууд тухайн жилийн баталсан төсвийн хүрээнд багтаан сургалт хөгжлийн арга

хэмжээг хэрэгжүүлж ирсэн байгаа нь сургалтын санхүүжилтийг тодорхой болгох хэрэгцээ шаардлага үүсэж байгааг илтгэж байна.

Төрийн байгууллагуудын албан хаагчдаас сурах шаардлагатай албан хаагч бүрийг сургах санхүүгийн боломж байхгүйгээс албан хаагчдыг сургах боломж хязгаарлагдмал байна.

Сургалт, хөгжлийн баталгааны “Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх” зорилтын хүрээнд “Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт”, “Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт”, “Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн” гэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа байна.

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 34/31 баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах” журмын дагуу төрийн албан хаагчдыг газарзүйн байршлаас үл хамааран сэлгэн, шилжүүлэн ажиллуулсан байна. Нэгтгэсэн судалгаагаар аудитад хамрах онд 15 албан хаагч сэлгэн ажиллуулсан, 102 албан хаагч шилжүүлэн ажиллуулсан ба ихэнх нь босоо бүтэцтэй байгууллагууд байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн цэгийг 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн ажиллуулан, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Хууль зүйн туслалцааны төв зэрэг байгууллагын 10 мэргэжилтэн төрийн 118 төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж эхэлсэн байна.

Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 499 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг байгуулж, газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/15 дугаар тушаалаар Баянхонгор аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийг 5 орон тоогоор баталсан байна.

Одоогийн байдлаар дээрх орон тоогоор ажиллаж Баянхонгор аймагт 3 цэгээр үйлчилгээ үзүүлж байгаа, харин хөдөөгийн 7 сумдад сумын ЗДТГ-ын хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн хавсран ажиллаж, цахим үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа бөгөөд төрийн үйлчилгээг цахимаар үзүүлэх албан хаагчийг сургах, дадлагажуулах ажил одоогийн байдлаар хангалтгүй байна. Иймд цаашид цахим үйлчилгээг нэвтрүүлэх албан хаагчдыг сургаж, чадварлаг, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах хүний нөөцийг бэлтгэх асуудлыг эрх бүхий байгууллагууд анхааралдаа авч, шат дараалсан арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна.

2.1.4 Жендерийн тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөг 2023-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2013 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 137 дугаар захирамжаар “Жендерийн тэгш байдлыг хангах аймгийн салбар хорооны журам”, мөн Баянхонгор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 03 дугаар 18-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор “Жендерийн эрх тэгш байдлын аймгийн салбар хорооны журам”-ыг тус тус баталсан байна.

Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, жендерийн салбар хорооны тайланг жил бүр Жендерийн үндэсний хороонд хүргүүлсэн байна.

Монгол улсын Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль, Тогтвортой хөгжлийн 5 дахь зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Баянхонгор аймгийн ЗДТГ-аас Жендерийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг боловсруулан ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 132 дугаар тогтоолоор Жендерийн тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөр (2016-2020 он), хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2016-2020) хүрэх үр дүн, ба үндсэн үзүүлэлтийг батлан хэрэгжүүлсэн бол үндэсний хөтөлбөртэй уялдуулан хөтөлбөрөө шинэчлэн боловсруулж 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлсэн.

“Жендерийн тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөр (2019-2022) нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 145 дугаар тогтоолоор 3 зорилт, 18 арга хэмжээ хэрэгжүүлж, 4 үр дүнг 6 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр батлагдсан байна.

Тус дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2020, 2021, 2022 онд хяналт шинжилгээ үнэлгээ хийж 2020 онд 70 хувь, 2021 онд 76.67 хувь, 2022 онд 90 хувьтай дүгнэсэн байна.

“Жендерийн эрх тэгш байдлыг хангах” (2019-2022) аймгийн дэд хөтөлбөрийн эцсийн үр дүн нөлөөнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

Уг үнэлгээгээр 2016-2019 онд төлөвлөсөн 18 үйл ажиллагааны 14 хэрэгжиж 77.8% хэрэгжилттэй, үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтээс 45.4% хэрэгжсэн, 36.4% хэрэгжих шатандаа, 18.2% хэрэгжээгүй. Энэ нь хөтөлбөрийн төлөвлөсөн үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийг хангахад анхаардаггүй, байгууллагуудын хамтын ажиллагаа, оролцоо хангалтгүй, санхүүжилт хүрэлцээгүй удирдлагын болон мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар тааруугаас болжээ гэж дүгнэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 04 -ны өдрийн А/618 дугаар захирамжаар батлагдсан 23 гишүүний бүрэлдэхүүнтэй “Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар хороо” орон нутгийн жендерийн үйл ажиллагааг чиглүүлэн ажиллаж байна.

Жендерийн тэгш байдлыг хангах салбар дундын 2023-2026 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 17/68 дугаар тогтоолоор баталсан ба 5 зорилт 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Төрийн байгууллагын байгууллагын удирдлагууд хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж байгаа боловч тэдгээр ажилтнуудад зориулсан орчны, сэтгэлзүйн, санхүүгийн, нийгмийн дэмжлэг байхгүй байна.

Аж ахуйн нэгж, байгууллагууд нь Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2²⁵ дахь хэсэгт заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах үүрэгтэй бөгөөд 2016-2024 онд 25-аас дээш ажилтантай 72 байгууллагад 62-118 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулсан нь хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо өссөн үзүүлэлттэй байгаа боловч Засгийн газрын 2009 оны “Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 26 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллахгүй байна.

²⁵ Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 2016-2024 онд 25-аас дээш ажилтантай 72 байгууллагад 62-118 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулан хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо өссөн үзүүлэлттэй байгаа хэдий ч зарим аж ахуйн нэгж, байгууллагууд нь Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2²⁶ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дээрх тогтоолоор аж ахуй нэгж, байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрт 2013-2024 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 250.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн ба төлбөрийн ихэнх хувь нь аж ахуйн нэгжээс төвлөрсөн байна.

Аймгийн ЗДТГ-ын дарга бөгөөд аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбарын зөвлөлийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 34 дүгээр удирдамжаар аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран “Ажил хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байр бэрхшээлийнх хэрэгцээ шаардлагад нийцсэн тохируулгатай байгаа эсэхэд үнэлгээ хийх тухай” ажлын хэсэг томилсон байна.

Тус ажлын хэсэгт Баянхонгор аймаг дахь ТАГ-ын аудитор ажиллаж, Эрдэнэмандал сургууль, 16 дугаар цэцэрлэг, Нэгдсэн эмнэлэг, Баянхонгор сумын ЗДТГ, “Цэвэр хот” ОНӨААҮГ, “Чандмань Баянхонгор” ХК-уудад ажиллан, аж ахуй нэгж, байгууллагад ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хийж гүйцэтгэж буй ажил, үйл ажиллагаатай танилцах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж буй ажлын байранд үнэлгээ хийж, тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тохируулгат орчин байгаа эсэхийг үнэлэх ажлыг хийсэн.

Сайн жишээ: Эрдэнэмандал сургууль 2 хөгжлийн бэрхшээлтэй ажилтныхаа ажлын байрыг өөрчилж хөнгөрүүлсэн байна, тухайлбал ариун цэврийн өрөөний үйлчлэгч байсан хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын байрыг энгийн үйлчлэгч, удаан зогсох боломжгүй тулгуур эрхтний бэрхшээлтэй багшийг нийгмийн ажилтнаар ажиллуулж байна. Нэгдсэн эмнэлэг 5 ажилтны ажлын байрыг өөрчилж хөнгөвчилсөн, 3 ажилтны ажлын цагийг хорогдуулсан цагаар ажиллуулж байна. Зарим төрийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууддаа биеэ эмчлүүлэх сувилуулах чөлөөг 7 хоног хүртэл чөлөө олгож түүнээс давсан тохиолдолд хуулийн дагуу лист олгодог байна.

Үзлэгт хамрагдсан байгууллагуудаас хөгжлийн бэрхшээлтэй иргэндээ тусгайлан нийгмийн хамгаалалын дэмжлэг үзүүлсэн байгууллага байхгүй байна. Харин Цэвэр хот ОНӨААҮГ нийт ажилчиддаа түлшний үнийн хөнгөлөлт үзүүлдэг тус хөнгөлөлтөд 3 хөгжлийн бэрхшээлтэй ажилтан хамрагдсан байна.

Хүснэгт 10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж байгаа байгууллагын судалгаа			
д/д	25 ба түүнээс дээш орон тоотой байгууллагын тоо	Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж байгаа	хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо
2016	72	26	62
2017	72	33	71
2018	72	33	70
2019	72	49	106
2020	72	55	114
2021	72	56	112
2022	72	57	112
2023	72	54	111
2024	72	61	118
Эх сурвалж: ХХҮГ-ийн тайлангаас			

²⁶ Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна.

Төрийн байгууллагад ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд бэрхшээлийн төрөл нь хүнд болон хөдөлгөөн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн ховор тул орчны тохируулга хийх зайлшгүй шаардлага байхгүй байна.

Аудитын илрүүлэлт

- Байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын зохион байгуулалт, хөдөлмөрлөх нөхцөл байдлын талаар тусгасан заалт байхгүй байгаа нь бүх байгууллага дээр нийтлэг;
- Барилга байгууламж, зам талбайн саадгүй байдлын хувьд тухайн байгууллагад ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй ажилтан тусгай зориулалтын шат, зам шаардахаар биш байгаа тул бэрхшээл тулгарах тохиолдол бага байна. Хэрэв хөдөлгөөн, тулгуур эрхтний хүнд хэлбэрийн бэрхшээлтэй ажилтан ажилд орсон тохиолдолд манай аймгийн бүх төрийн байгууллагуудад 2-оос дээш давхар луу гарах цахилгаан шат байхгүй, үүдний хэсгийн тэргэнцэртэй хүний зам болон хаалганы босго нь өндөр дангаараа бие даан ажилдаа ирж буцах боломжгүй нөхцөл байдалтай;
- Хүнд хэлбэрийн бэрхшээлтэй иргэдийн ажилд авах сонирхолгүй, тэдгээрт зориулсан гарц, цахилгаан шат байхгүй, байгаа зам нь стандартын шаардлага хангаагүй зэрэг зөрчлүүд нийтлэг;
- Аймгийн хэмжээнд 25-аас дээш албан хаагчтай төрийн болон орон нутгийн өмчит 72 байгууллагаас 11 байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь заалт, Засгийн газрын 2009 оны “Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 26 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж байгаа байгууллагуудын дотоод журам, хамтын гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах орчныг тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тохируулгат орчин нөхцөлөөр хангаж байгаа эсэх мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь заалтын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.2. И-Монголиа ашиглан систем хооронд өгөгдөл солилцох үйл ажиллагааг хөгжүүлснээр иргэд шаардлагатай мэдээллийг цахимаар хүлээн авч байгаа нь цаг хугацаа, эдийн засгийн хэмнэлтийг бий болгосон байна.

2.2.1. Мэдээлэл, технологи харилцаа холбооны газраас 2020 онд тусгай тоног төхөөрөмжөөр ханган нийт 118 үйлчилгээг аймгийн төв болон сумдад гаргах боломжтой болсноор иргэдэд төрийн үйлчилгээ хүнд сурталгүй, шуурхай, цогц байдлаар хүрэх боломжтой болсон, И-монголиа цахим хуудас ашиглан иргэд шаардлагатай лавлагаа, мэдээллийг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран авах боломжтой болжээ.

2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн аймгийн ЗДТГ-ын дэргэд байгуулагдсан “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Хууль зүйн туслалцааны төв зэрэг байгууллагын 10 мэргэжилтэн төрийн 118 төрлийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн ба 2020 онд 16,128 иргэнд үйлчилгээ үзүүлсэн, 2021 онд 25,835 иргэн, 2022 онд 31,843 иргэнд нэг цэгээс үйлчилгээг үзүүлсэн байна.

Төрийн үйлчилгээг иргэдэд зайнаас богино хугацаанд шуурхай үйлчлэх зорилгоор Үндэсний цахим үйлчилгээний нэгдсэн систем И-Монголиа нэвтрүүлж эхэлсэн цагаас хойш Баянхонгор аймгийн хэмжээнд 2020 онд 2,856 иргэнд, 2021 онд 3,682 иргэнд, 2022 онд 4,367 иргэнд лавлагаа, тодорхойлолт гарган өгч ажилласан байна.

Баянхонгор аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс байгуулагдсан хугацаанаас хойш И-Монголиа операторын системээр дамжуулан 2023 онд 35 байгууллагын 6,000 үйлчилгээ, 2024 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар 43 байгууллагын 16,800 үйлчилгээг иргэдэд хүргэсэн байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд орон нутгийн онцлогтой төрийн үйлчилгээг цахимжуулах, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2022 онд 32 төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээ, 2024 онд 6 нэр төрлийн үйлчилгээг нэвтрүүлсэн нь давуу талтай байна.

И-Монголиа операторын системээр 2023 онд эрэлттэй 10 үйлчилгээний жагсаалтад шинжилгээний хариуг 680 удаа, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт 569 удаа, иргэний үнэмлэхийн лавлагааг 463 удаа авсан нь хамгийн их тоон үзүүлэлттэй байсан бол 2024 оны эхний 11 сарын байдлаар шинжилгээний хариуг 1,852 удаа, иргэний үнэмлэхийн лавлагааг 1,258 удаа, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолтыг 968 удаа авсан нь хамгийн их тоон үзүүлэлттэй байна.

Ийнхүү систем хооронд өгөгдөл солилцох үйл ажиллагааг хөгжүүлснээр цахим орчин мэдээллийг цаг алдалгүй, нотариатаар гэрчлүүлэх шаардлагагүйгээр, төрийн албан хаагч бүр дээр очиж үйлчилгээ авахгүй байгаа, 7 сумдад үйлчилгээг олгож эхэлснээс сумын төвөөс мэдээллийг авч байгаа зэрэг нь цаг хугацаа, эдийн засгийн хэмнэлт бий болсон давуу талтай байна.

2.2.2 Төрийн үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран түргэн шуурхай авах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс цахимаар үзүүлж байгаа үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, үүнтэй холбоотойгоор цахим орчинд ажиллах албан хаагчдыг сургах, хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг хангах нь зүйтэй байна.

2.3 Төрийн үйлчилгээний ил тод, нээлтэй байдлыг 16 салбараар үнэлсэн иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа “Дунд” үнэлгээтэй байна.


Баянхонгор аймгийн ЗДТГ-аас irgen.bayankhongor.gov.mn нэгдсэн системийн судалгааг 15 чиглэлээр иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг авч 2023 оны эцэст 1,293 иргэн, 2024 оны эхний 01 дүгээр улиралд 1,037 иргэн, 2 дугаар улирлаар өссөн дүнгээр 2,690 иргэний судалгааны дүнг нэгтгэн, дүгнэлт гаргаж ажиллажээ.

Судалгаанд хамрагдсан 2,690 иргэний 1,231 иргэн нь төрийн байгууллагын албан хаагчид байсан ба үнэлгээг 1-5 оноогоор /1 маш муу, 5 маш сайн/ үзүүлэлтээр дүгнэж, дараах байдлаар үнэлжээ. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний ТОП-10 байгууллагын нэгээр Баянхонгор аймгийн ЗДТГ шалгарсан байна.

Иргэдээс 15 чиглэлд ирүүлсэн 2,690 иргэний саналыг нэгтгэсэн дүнгээс харахад эрүүл мэндийн салбарын ажилтнуудын ёс зүй, хандлага, мэдлэг ур чадварыг дунджаар 3.6 оноогоор дүгнэсэн бол боловсролын салбарын сургалтын чанар, багш нарын мэдлэг ур чадварыг 3.6 оноогоор, ёс зүйг 3.7 оноогоор дүгнэжээ.

Харин дэд бүтцийн салбарын газар олголтын үйлчилгээнд 2.5 оноо, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ээлтэй орчин бүрдүүлсэн эсэхэд 2.8 оноо, татварын үйл ажиллагааны түргэн шуурхай байдал, харилцааны ёс зүй, санал гомдлоо илэрхийлэх боломж нээлттэй байдлыг 2.8 оноогоор үнэлсэн нь доогуур үзүүлэлттэй гарчээ.

Төрийн үйлчилгээг нэг дороос иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний нэг цэгийн үйлчилгээний саналыг 106 иргэн өгсөн ба дараах байдлаар үнэлгээ өгсөн байна.



Хүснэгт 11.Төрийн нэг цэгийн үйлчилгээнд өгсөн санал

№	Асуулт	Оноо
1	Үйлчилгээний түргэн, шуурхай байдалд үнэлгээ өгнө үү.	3.6
2	Үйлчилгээний нэгдсэн төвийн ажилчдын харилцаа, хандлагыг үнэлнэ үү?	3.6
3	Үйлчилгээний нэгдсэн төвийн ажилчдын мэдлэг, ур чадварт үнэлгээ өгнө үү.	3.5
4	Төрийн үйлчилгээг цахимаар авахад хүндрэл учирч байна уу?	3.5

Эх сурвалж: irgen.bayankhongor.gov.mn

Орон нутгийн үйлчилгээний саналыг нийт санал өгсөн иргэдийн 42.7 хувь буюу 1,148 иргэн санал өгч хөдөө орон нутагт үзүүлж байгаа төрийн үйлчилгээг дараах байдлаар дүгнэжээ.

Хүснэгт 12.Орон нутгийн байгууллагад өгсөн санал

№	Асуулт	Оноо
1	Төрийн байгууллагуудын бодлого шийдвэр, үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөц болон үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл ил тод байж чаддаг уу?	3.6
2	Сумын эрүүл мэндийн төвөөс эрүүл мэндийн шаардлагатай үйлчилгээг бүрэн авч чадаж байна уу?	3.7
3	Сумын эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилчдын ёс зүй, хар	3.7
4	Сумын эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилчдын мэдлэг, ур чадварт үнэлгээ өгнө үү.	
5	Боловсролын байгууллагын сургалтын чанарт үнэлгээ өгнө үү. (СӨБ, сургууль)	3.8
6	Багш нарын мэдлэг, ур чадварт үнэлгээ өгнө үү?	3.8
7	Багш нарын ёс зүй, харилцаа хандлагад үнэлгээ өгнө үү?	3.8
8	Сумын соёлын төвийн үйл ажиллагаанд үнэлгээ өгнө үү.	3.6

Эх сурвалж: irgen.bayankhongor.gov.mn

Иргэдээс irgen.bayankhongor.gov.mn нэгдсэн системд санал өгч байгаа иргэдийн тоо бага, судалгааны дүнд үндэслэн боловсруулсан тайлан, мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагад өгч ажиллаагүй байна. Иймд цаашид тус системийн талаарх мэдээллийг иргэдэд хүргэх, санал асуулгад оролцох иргэдийн тоог нэмэгдүүлэх, санал асуулгын дүнгийн нэгтгэлд дүн шинжилгээ хийж, тайлан, судалгааг холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллах нь зүйтэй байна.

2.3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2²⁷-т заасан чиг үүргээ төрийн байгууллагууд биелүүлж байгааг дүгнэх зорилгоор аудитын явцад Баянхонгор аймгийн ХХҮГ-аас 2012 оноос 2024 оны эхний 9 сарын байдлаар төрийн байгууллагуудаас ирүүлсэн сул чөлөөтэй ажлын байрны захиалга өгсөн судалгааг гаргуулан

²⁷ Ажил олгогч нь ажиллах хүч болон ажлын байрны холбогдолтой мэдээллийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид гаргаан өгөх, эсхүл түүний бүртгэл, мэдээллийн сүлжээнд бүртгүүлж, мэдээллээ байршуулах, мэдээлэлд оруулж байгаа өөрчлөлтийг тухай бүрд нь хийж байх үүрэгтэй бөгөөд ажил олгогч нь нийт ажлын байрныхаа талаарх мэдээллийг оны эхэнд нэг удаа, шинээр бий болсон болон байхгүй болсон ажлын байрны талаарх мэдээллийг улирал тутам, сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээллийг тухай бүр нь энэ хуулийн 20.7-д заасан маягтын дагуу харьяалах аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан, хөдөлмөрийн биржид гаргаж өгнө.

авч, дүн шинжилгээ хийхэд 2013-2024 онд давхардсан тоогоор 110 байгууллага 472 ажлын байрны захиалга өгснөөс 207 ажлын байрыг ажилд зуучилсан байна.

Тус газраас ирүүлсэн судалгаагаар 2022 оноос төрийн байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга нэмэгдсэн нь хөдөө сумдын төрийн байгууллагаас өгөх захиалгын тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Иймд төрийн албан хаагчийн сул орон тооны захиалгыг ХХҮГ-т бүртгүүлэх ажлыг төрийн байгууллагуудад чиглэл өгч ажиллах зөвлөмжийг ТАСЗ-д хүргүүлэв.

2.3.2. Байгууллагын ил тод байдлыг Шил ажиллагаа болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн 5 төрлийн 46 мэдээллээр хянахад аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын дундаж үнэлгээ 39.9 хувьтай ба тус үнэлгээг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс системд оруулсан мэдээллийн дагуу үнэлжээ.

Тус газраас хийсэн үнэлгээгээр 2022 онд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс 100 хувиар, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК 29.2 хувиар үнэлэгдсэн, 2023 онд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 93.8 хувиар, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК 0.9 хувиар, 2024 оны эхний хагас жилээр аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтэс 100 хувиар, Биеийн тамир, спортын газар 2.0 хувиар үнэлэгдсэн байна.

Баянхонгор аймгийн ХШҮХ-ээс үнэлсэн үнэлгээнд орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нэгтгэгдэн мэдээллийг оруулснаар ил тод байдал нэмэгдсэн бөгөөд сүүлийн 3 удаагийн үнэлгээг нэгтгэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 13.Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяаны байгууллага үнэлгээ

Тайлант хугацаа	Харьяа байгууллага	Сумдын ЗДТГ
2022	78.5	77.7
2023	39.5	34.3
2024 оны эхний хагас жил	51.4	62.1

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ХШҮХ

2.3.3. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ээс ирүүлсэн мэдээллээр АТГ-ын мэдээллээр Баянхонгор аймаг Шударга байдлын үнэлгээгээр 2015 онд 73.0, 2016 онд 67.8, 2018 онд 66.7, 2019 онд 71.3, 2021 онд 68.8, 2022 онд 68.5 оноогоор үнэлэгдсэн ба бусад оны мэдээллийг судалгаа нийтлэгдээгүйгээр ирүүлсэн байна.

Шударга байдлын үнэлгээний хэсэгт авлигын индекс багтдаг бөгөөд авлигын индексийг авлига, хээл хахуулын үнийн дүн, давтамж зэрэг 16 үзүүлэлтээр үнэлдэг байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд авлигын индексийг тодорхойлсон мэдээллийг тус хэлтсээс 2011 оны байдлаар ирүүлсэн нь аудитын хамрах хугацаанд хамааралгүй байна.

Аудитаар нийт 9 зөрчил илрүүлснээс Баянхонгор аймгийн Засаг даргад 3, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын даргад 1, Баянхонгор аймаг дахь ТАСЗ-д 5 зөвлөмжийг өгч, ҮАГ-аар дамжуулан ТАЗ-д 3 саналыг хүргүүлэхээр уламжлав.

---oOo---

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн хүрээнд мөрдөх стратеги төлөвлөгөө, хүний нөөцийн тусгайлсан бодлогын баримт бичгийг батлаагүй, дутагдалтай хүний нөөцийн нэгдсэн судалгаа байхгүй байна.
2. Төрийн байгууллагуудын хүний нөөцийн асуудлыг зохицуулж байгаа хууль тогтоомжийг албан хаагчдад ээлтэй, эрх ашгийг хамгаалахаар баталж мөрдсөн байгаа ч хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллаж чадахгүй байна.
3. Баянхонгор аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж байгаа боловч илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийж, төрийн байгууллагуудад нэгдсэн зөвлөмж, чиглэл өгч, түүний хэрэгжилтийг нэгтгэн дүгнэн үр нөлөөг тооцож ажиллаагүй байна.
4. Баянхонгор аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн архивын баримтууд дутуугаас мэдээллийг аудитын багт бүрэн ирүүлээгүй, Төрийн албаны цахим хуудаст ТАСЗ-ийн гишүүдийн мэдээллийг шинэчлээгүй, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.1, 5.2 дахь заалтыг мөрдөж ажиллаагүй байна.
5. Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудад албан хаагчийн хувийн хэргийн бүрдэл хангалтгүй, албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн бус албан хаагчийг ажиллуулсан зөрчлүүд илэрсэн байна.
6. Төрийн албаны зөвлөлийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчилтэй томилгоо жил бүр давтагдан гарсан, өмнөх жилийн зөрчлийг бүрэн арилгаагүй байна.
7. “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”-ын дагуу Төрийн албаны зөвлөл” Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд тавих хяналт хангалтгүйгээс нягтлан бодогч нар мэдээллийг өөрсдөө оруулж байгаа, мэдээллийг оруулах чиг үүргийг холбогдох албан тушаалтны албан тушаалын тодорхойлолтод тусгаагүй, төрийн албанд ажилласан хугацааг зөрүүтэй оруулсан, тэтгэвэрт гарсан, шилжсэн, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын мэдээллийг системд тухай бүр оруулаагүй зэрэг нийтлэг зөрчилтэй байна.
8. Сумдын ЭМТ, Баянхонгор аймгийн Сум дундын Ойн анги, “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨТҮГ-ын даргыг удирдах ажилтны сонгон шалгаруулалтад ороогүй байхад аймгийн Засаг даргын захирамжаар томилсон нь ТАЗ-ийн 2013 оны 60, Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журмыг зөрчсөн байна.
9. Иргэд, олон нийтээс ирүүлсэн саналд үндэслэн төрийн үйлчилгээг сайжруулах, цахим төрийн үйлчилгээг нэвтрүүлэхэд төрийн албан хаагчдыг сургаж, чадваржуулах байдал дутмаг байна.
10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулж байгаа байгууллагын дотоод журам, хамтын гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын ажиллах нөхцөл, ажлын зохион байгуулалтын талаар дурдсан заалт байхгүй, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь заалтын дагуу 25-аас дээш албан хаагчтай 11 байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА

1. Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн хүрээнд мөрдөх стратеги төлөвлөгөө, хүний нөөцийн судалгаанд тулгуурлан тусгайлсан бодлогын баримт бичгийг баталж хэрэгжүүлэх
2. Хүний нөөцийн аудит хийх боловсон хүчнийг нэмэгдүүлэн, хөдөлмөрлөх эрхийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, сургалт явуулах зэрэг хүний нөөцийн бодлогын зорилтыг хэрэгжүүлэхдээ хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулж, хамтран ажиллах
3. Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны албан тушаалын тодорхойлолтыг батлуулж, сонгон шалгаруулалтын дүнгийн дагуу томилгоог хуулийн дагуу хийх
4. Хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж байгаа байгууллагуудын дотоод журам, хамтын гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах орчныг тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тохируулгат орчин нөхцөлөөр хангаж байгаад хяналт тавьж байх

ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.ЭНХЖАРГАЛ ТАНАА

1. Улсын төсвийн санхүүжилтээр Удирдлагын академийн сургалтад хамрагдаж буй албан хаагчтай сургалтын гэрээг байгуулж, төгсөөгүй тохиолдолд зардлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг авч ажиллах

ГУРАВ. БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛД

1. Төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, бусад асуудалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх бүрд илэрч буй алдаа, зөрчилд үндэслэн нэгдсэн арга зүй, зөвлөмжийг хугацаатай өгч, хэрэгжилтийг тооцож, үр дүнг нэгтгэн тайлагнаж ажиллах
2. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу 2025 онд ТЕЗ-ын харьяа бүх байгууллагын албан хаагчдын хувийн хэргийг шалгах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх
3. Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, баримт материалын цаасаар болон цахим сууриар байгууллагын архивд хүлээлгэн өгөх, цахим хуудаст мэдээллийг шинэчлэх
4. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.1, 5.2 дахь заалтын дагуу салбар зөвлөлийн үйл ажиллагааг журмын дагуу үнэн, зөв, бүрэн тайлагнах
5. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын ХНУМТ цахим системд мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулж байгаад хяналт тавьж ажиллах

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААР ДАМЖУУЛАН ХОЛБОГДОХ ГАЗРУУДАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

НЭГ. ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛД

1. ТАЗ-ийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6 дахь заалтын дагуу Төрийн албаны зөвлөлийг орон нутагт бие даасан хараат бус байдлыг хангах зорилгоор байгуулж, бүтэц орон тоог нэмэгдүүлэх
2. ТАЗ-ийн www.csc.gov.mn цахим хуудаст баталсан албан тушаалын тодорхойлолтуудыг бүрэн байршуулах
3. Төрийн байгууллагуудад гарсан сул орон тоо гарсан тухай бүр холбогдох мэдээллийг ХНУМТ цахим системээс Төрийн албаны салбар зөвлөлд мэдээлэл ирэх зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, программын хөгжүүлэлтийг хийх замаар тус зөрчлийг давтан гаргахгүй байх